БАТЛАВ: ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИНЫ БОДЛОГО
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА
................................................... Б.БУЯННЭМЭХ

# УЛААНБААТАР ХОТ НАЛАЙХ ДҮҮРГИЙН 6-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ, ГОРХИ ТЭРЭЛЖ БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗАРТ “МӨНХ АРИУН УНДАРГА” ХХК-ИЙН “САЦ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БААЗ” ТӨСЛИЙН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

**ХЯНАСАН:**
ХБОБЗГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН
................................ П.ШИНЭЦЭЦЭГ

**ХЯНАСАН:**
ГОРХИ-ТЭРЭЛЖ БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН ................................ Н.ЭРДЭНЭБИЛЭГ

**БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:**
“МӨНХ АРИУН УНДАРГА” ХХК-ИЙН ЗАХИРАЛ .............................. Д.АРИУНЦЭЦЭГ

**БОЛОВСРУУЛСАН:**
“МӨНХ АРИУН УНДАРГА” ХХК-ИЙН МЕНЕЖЕР .............................. Г.БОЛОРЦЭЦЭГ

УЛААНБААТАР
2023

# ГАРЧИГ


**НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

1.1 Төслийн ерөнхий мэдээлэл
1.1.1. Төслийн нэр
1.1.2. Төслийн зорилго
1.1.3. Төсөл хэрэгжүүлэгч
1.1.4. Төслийнбайршил
1.1.5. Төслийн хүчин чадал

**ХОЁР. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ**

**ГУРАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЛЭЛТ**

**ДӨРӨВ. НӨХӨН СЭРГЭЭЛТ**

**ТАВ. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ**

**ЗУРГАА. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭ**

**ДОЛОО. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ**

**НАЙМ. ХИЙМИЙН БОДИСЫН ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТ**

**ЕС. ХОГ ХЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ**

**АРАВ.УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

**АРВАН НЭГ. ОРЧИНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ**

# НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

## 1.1 Төслийн ерөнхий мэдээлэл

1.1.1. *Төслийн нэр*

“САЦ” жуулчны бааз

1.1.2 *Төслийн зорилго*

“Мөнх Ариун Ундарга” ХХК-ий “САЦ” жуулчны бааз нь олон улсын түвшинд нийцсэн үйл ажиллагаа явуулах, улс орныхоо аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулах, үйлчилгээний соёлыг дээд зэргээр ханган, зочдынхоо сэтгэл ханамжийг мэдэрч хөрөнгө оруулалтаа эргэж нөхөх, ажилчдынхаа амьдралын баталгааг сайжруулан, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэн, ажлын байрны нөхцөлийг дэмжсэнээр нийгэм, эдийн засагт бодит үр дүнгээ нэмэгдүүлэхэд оршино.

1.1.3 *Төсөл хэрэгжүүлэгч*

“Мөнх Ариун Ундарга” ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 9011156052

Регистрийн дугаар: 5235359

Хаяг: Нийслэлийн Хан-Уул дүүргийн 3-р хороо, Үйлдвэр Шаравын гудамж, 12 тоот

Утас: 70143302, 91771111.

1.1.4 *Төслийн байршил*

Улаанбаатар хотын Налайх дүүргийн 6-р хороо, Арагант нэртэй газарт 1 га газарт байрлана.



# “МӨНХ АРИУН УНДАРГА” ХХК-ийн “САЦ” ЖУУЛЧНЫ БААЗЫН 2023 ОНЫ БАЙГАЛЬ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН


5



Зураг 1. “САЦ” жуулчны баазын харагдах байдал




Зураг 2. “САЦ” жуулчны баазын байршил




1.1.5 *Төслийн хүчин чадал*

“САЦ” жуулчны бааз нийт 3 төрлийн 28 өрөөтэй. Үүнээс:

- Гэр бүлээрээ ирж буй зочдод зориулсан өрөө -10
- 1 ортой энгийн өрөө - 8
- 2 ортой энгийн өрөө - 9

зэрэг болно. Эдгээрээс гадна:

- 40 хүн хүлээн авах чадалтай хурлын танхим - 1
- 60 хүний багтаамжтай ресторан - 1
- Кароке өрөө - 1
- Алжаал тайлах өрөө -1
- 16 ширхэг модон байшин - 16

тус тус байрладаг.

“САЦ” жуулчны бааз нь орчин үеийн 1 том гал тогоотой бөгөөд гал тогооны тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон. “САЦ” жуулчны баазаар үйлчлүүлснээр Монгол тогооч нарын бэлтгэсэн европ, ази хоол, зууш амттанаас зооглох боломжтой. Хурлын танхим нь олон улсын стандартад нийцсэн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон.

## ХОЁР. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

“САЦ” жуулчны баазын гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг тогтоохдоо урьд өмнө хийгдсэн байгаль орчин, нийгэм эдийн засгийн холбогдолтой судалгааны материалууд, төслийн өнөөгийн төлөв байдлыг харгалзан үзэж тодорхойлов.

Үйлчилгээний үе шатуудын байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөллүүд нь харилцан адилгүй байна.

Үүнд:

- Халаалтын зориулалтаар сайжруулсан түлш хэрэглэх үед бага боловч агаар бохирдуулах эх үүсвэр болно.
- Хоол бэлтгэлийн явцад их, бага тодорхой хэмжээгээр ус хэрэглэх, хоол хийх явцад гарах утаа, хиншүү зэргээс дотоод орчны агаарын чанарт нөлөөлнө. Хоол хүнсний үлдэгдэл, хүнсний ногооны хаягдал, сав баглаа боодол, хайрцаг гэх мэт хаягдлууд гарна.
- Ахуйн хатуу ба шингэн хог хаягдал нь хөрсийг бохирдуулж, орчны өнгө үзэмж, эрүүл ахуйг дордуулах магадлалтай.
- Хүмүүсийн бөөгнөрөл, аялал зугаалгаас гарах дуу чимээ нь амьтны аймаг болон хүний эрүүл мэндэд дарамт үүсгэнэ.

*Төслийн болзошгүй нөлөөллөөс үүдэн бий болох гол сөрөг нөлөөллүүд нь:*

- Автомашины утаа, жуулчины баазын халаалтанд ашиглах сайжруулсан нүүрсний шаталт зэргээс агааын чанарт нөлөөлөх.
- Олон хүмүүс цуглаж, аялал зугаалга зохион байгуулах үед дуу чимээний улмаас амьтдыг үргээх.

- Сул талбайг арчилж тордоогүйгээс хөрс эвдрэлд орох, ургамал талхлагдах.
- Хатуу хог хаягдал голын усыг бохирдуулах.
- Ахуйн зориулалтаар усыг их хэмжээгээр хэрэглэснээс газрын доор усны нөөцөд сөргөөр нөлөөлөх.
- Шингэн хаягдлыг зөөж тээвэрлэх үед бохир ус хөрсөнд асгарах.

## ГУРАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЛЭЛТ

3.1.1 Ахуйн хог хаягдлыг ангилан ялгаж, битүүмжлэл сайтай түр хадгалах саванд байрлуулан, Налайх дүүргийн “Тохижилт үйлчилгээ “ ОНӨААТҮГ-тэй байгуулсан Хог хаягдлыг ачиж тээвэрлэх гэрээний дагуу тогтмол хугацаанд зайлуулаж байна.

3.1.2 Мэргэжлийн байгууллагаар хортон шавьжны устгал хийлгэх гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. “Хунт хайрхан” ХХК, Ахуйн шавьж мэрэгч, устгал халдваргүйтгэлийн ажлын гэрээ дугаар №0518.

3.1.3 Жуулчины баазын талбайн гаднах орчиныг цэвэр цэмцгэр байлган, Налайх дүүргийн 6-р хороотой хамтран ажиллах Тохижилт, цэвэрлэгээний гэрээний дагуу тэрэлж орчмын 50м-ийн радиустай талбайг байнга цэвэрлэж байна.

3.1.4 Жуулчины баазын хашаан дотор 1000м2 талбайд зүлэгжүүлэлт хийж 200 ширхэг голт бор, 200 ширхэг буйс, 2 ширхэг монос мод тарьж, явган хүний зам хийж хүний хөл хөдөлгөөн ихэссэнээс хөрс, уггамал талхлагдахаас урьдчилан сэргийлэв.

3.1.1 Шингэн хаягдлыг “МАРГАД ЭРДЭНЭ УУЛ” ХХК-тай байгуулсан Хэрэглээнээс гарсан шингэн хог хаягдал зөөвөрлөх гэрээний дагуу зайлуулаж байна.

3.1.2 Сөрөг нөлөөллийг бууруулхад гарсан нийт зардал.

| № | Байгууллагын нэр | Нэгж зардал | Нийт зардал |
|---|---|---|---|
| 1 | “Тохижилт үйлчилгээ “ ОНӨААТҮГ | Хогны төлбөр 160000төг.<br>Хог түрэлт 220000төг. | 380000 төг |
| 2 | “Хунт хайрхан” ХХК | Мэрэгчгүйтгэлийг 50000төг.<br>ХалдваргүйтгэлийгГипохлорид Кальци 1кг 10000төг. | 520000 төг |
| 3 | “Маргад Эрдэнэ уул” ХХК | Шингэн хог хаягдал | 2295000 төг |
| 4 | Хот тохижилтын газар | Голт бор-200ш, Буйлс-200ш, Монос-2ш | 2300000 төг |
| 5 | Стандарт, хэмжил зүйн газар | Цэвэр ус, Бохир ус, Хөрс Шинжилгээ | 312000 төг |
| 6 | “Цээмаа хөгжил” ХХК | Wilo Насос | 913000 төг |
| 7 | Минжит булган констракшн | Явган замын хавтан | 1700000 |

| | | | |
|---|---|---|---|
| 8 | Нийт | | 8420000 төг |

## Ахуйн хог хаягдал түр хадгалах сав



## Явган хүний зам



## ГОЛТ БОР



## ГОЛТ БОР



## БУЙЛС





## МОНОС







## ДӨРӨВ.НӨХӨН СЭРГЭЭЛТ

4.1.1 Жуулчины баазын үйл ажиллагааны үед газрын хэвлийг ухах, техноген эвдрэлд оруулах үйл явц байхгүй бөгөөд цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжийн ажлыг жил бүр хийнэ.

## ТАВ. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ДҮЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ

5.1.1 Хууль эрх зүйн хүрээнд судалж байна.

## ЗУРГАА.НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭ

6.1.1 Тухайн төслийн үйлдвэрлэлийн болон эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд зайлшгүй нүүлгэх шаардлагатай иргэн, оршин суугчид, айл өрх, байгууллага байхгүй болно.

## ДОЛОО. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ

7.1.1 Төсөл хэрэгжих орчинд түүх соёл, археологийн олдвор олдоогүй бөгөөд харин төсөл хэрэгжих газарт ойрхон Буддын шашны Арьяабалийн сүм байрлана. Энэхүү сүм нь уулын энгэрт байрладаг, сүм рүү хүрэх явган хүний зам талбайг тохижуулсан байдаг. Төслийн үйл ажиллагаанаас энэхүү сүмд үзүүлэх нөлөөлөл байхгүй.

## НАЙМ. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТ

8.1.1 Жуулчны баазын үйл ажиллагаанд хүний эрүүл мэнд болон байгаль орчинд хортой нөлөө үзүүлэх, хохирол учруулах хортой болон аюултай химийн бодис хэрэглэхгүй болно.

## ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

| № | Байгууллагын нэр | Нэгж зардал | Нийт зардал |
|---|---|---|---|
| 1 | “Тохижилт үйлчилгээ “ ОНӨААТҮГ | Хогны төлбөр 160000төг.<br>Хог түрэлт 220000төг. | 380000 төг |
| 2 | “Маргад Эрдэнэ уул” ХХК | Шингэн хог хаягдал | 2295000 төг |
| 3 | Нийт | | 2675000 төг |

Жич: Ахуйн хатуу, шингэн хог хаягдлыг зөвхөн тээвэрлэн зайлуулах зардал тооцогдсон болно.

## АРАВ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

10.1.1Байгаль орчныг хамгаалах сургалт, Хөдөлмөр хамгааллын дотоод сургалт, Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулав. Мөн шаардлагатай тоног төхөөрөмжөөр тоноглов.

Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэв.






# АРВАН НЭГ. ОРЧИНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

11.1.1 Налайх дүүргэг дэх Стандарт, хэмжил зүйн газрын лабораториор 2023 .10.19 өдөр Хөрс, Бохир ус, Ундны усны чанар аюулгүйн байдалд үнэлгээ өгөх зориуулалтаар дээж авч шинжилгээ хийв.

10/30/23, 11:27 AM GASI-LIMS

Хүнсний Аюулгүй Байдлын
Үндэсний Лавлагаа Лабораторийн
ерөнхий захирлын 2023 оны 01 сарын
02-ны өдрийн А/02 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт Маягт 00-59

MNAS Accreditation system
TL 06-17
MNS ISO/IEC 17025

**СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН НИЙСЛЭЛИЙН САЛБАР НАЛАЙХ ДҮҮРЭГ ДЭХ ЛАБОРАТОРИ**
Улаанбаатар хот, Налайх дүүрэг, Дамдины гудамж
Утас: 70233301

**ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН**
***CERTIFICATE OF ANALYSIS***

**Бүртгэлийн дугаар** /Registration number/ : 23-151
**Шинжилгээ хийлгэх хүсэлт гаргасан газрын нэр :** Мөнх ариун ундарга ХХК
/The name of customer's request for analysis/
**Дэд лабораторийн нэр** /Name of the sub laboratory/ : Нян судлалын хяналтын лаборатори; Хими, хор судлалын хяналтын лаборатори

| Дээжийн тодорхойлолт /Sample description/ | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Дээжийн дугаар** Sample number | **Дээжийн нэр** Name of sample | **Цувралын дугаар** Batch number | **Үйлдвэрлэсэн улс** The country of original manufacturer | **Бүтээгдэхүүний хүчинтэй хугацаа** Date of expiry | **Дээжийн тоо хэмжээ** Quantity of the sample |
| 425 | Ундны ус | | Монгол Улс | Тодорхойгүй | 2.0 л |
| 426 | Бохир ус | | Монгол Улс | Тодорхойгүй | 2.0 л |
| 427 | Хөрс-1 | | Монгол Улс | Тодорхойгүй | 500.0 г |
| 428 | Хөрс-2 | | Монгол Улс | Тодорхойгүй | 500.0 г |
| 429 | Хөрс-3 | | Монгол Улс | Тодорхойгүй | 500.0 г |

| **Хүлээн авсан огноо** Date of receipt | **Шинжилгээ дууссан огноо** Date of test completion | **Хэвлэсэн огноо** Date of issue of the report |
|---|---|---|
| 2023 он 10 сар 19 өдөр | 2023 он 10 сар 30 өдөр | 2023 он 10 сар 30 өдөр |

| **Дээжийн дугаар** Sample number | **Шинжилгээний аргын стандарт** Method of analysis | **Шинжилсэн үзүүлэлтийн нэр, хэмжих нэгж** Test parameter, unit | **Шаардлага** Test specification, unit | **Шинжилгээний дүн** Test results |
|---|---|---|---|---|
| 425 | MNS 4430:2005 | Нийт төмөр | <0.3, мг/л | 0.58 |
| | MNS ISO 7890-3:2001 | Нитрат | <50.0, мг/л | 3.12 |
| | MNS 4431:2005 | Нитрит | <1.0, мг/л | 0.0 |
| | MNS ISO 10523:2001 | pH | 6.5-8.5 | 7.15 |
| | MNS 6271:2011 | Сульфат | <500.0, мг/л | 26.8 |
| | MNS ISO 6878:2011 | Фосфат | <3.5, мг/л | 0.0 |
| | MNS 6272:2011 | Фтор | 0.7-1.5, мг/л | 0.16 |
| | MNS ISO 6059:2001 | Хатуулаг | <7.0, мг-экв/л | 1.2 |
| | MNS 4424:2005 | Хлорид | <350.0, мг/л | 28.3 |
| | MNS 4423:1997 | Хуурай үлдэгдэл | <1000.0, мг/л | 176 |
| | MNS ISO 6222:1998 | *ББЕТ* | 1мл-т 100 | 1 мл-т 38 |
| | MNS ISO 19250:2017 | *Salmonella spp* | 25 мл-т илрэхгүй | 25 мл-т илрээгүй |
| | MNS ISO 9308-1:1998 | *E.coli* | 100 мл-т илрэхгүй | 100 мл-т илрээгүй |
| 426 | MNS 5668:2006 | *ББЕТ* | - | 2,6*10^5 |
| | MNS 5668:2006 | Гэдэсний бүлгийн савханцарын таньц | - | 0.004 |
| | MNS 5668:2006 | Clostridium perfringens | - | 0.001 |
| | MNS 5668:2006 | Эмгэгтөрөгч нян | 1 мл-т илрэхгүй | 1 мл-т илрээгүй |
| | MNS ISO 5815-1:2015 | Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч | <20, мгО/л | 16.0 |
| | MNS ISO 7890-3:2001 | Нитрат | -, мг/л | 2.1 |
| | MNS ISO 10523:2001 | pH | 6-9 | 7.22 |
| | MNS ISO 9280:2001 | Сульфат | -, мг/л | 132.6 |
| | MNS ISO 11923:2001 | Умбуур бодис | <50, мг/л | 44.0 |
| | MNS ISO 6060:2001 | Химийн хэрэгцээт хүчилтөрөгч | <50, мг/л | 48.0 |
| | MNS 4424:2005 | Хлорид | -, мг/л | 170.0 |
| | MNS ISO 6777:2001 | Нитрит | -, мг/л | 0.028 |
| | MNS ISO 6878:2011 | Фосфат | -, мг/л | 3.5 |
| 427 | MNS 6341:2012 | *ББЕТ* | - | 2,8*10^5 |

gasi.shinjilgee.mn/generalTestPage?sid=0# 1/2

11:27 AM GASI-LIMS

| Дээжийн дугаар *Sample number* | Шинжилгээний аргын стандарт *Method of analysis* | Шинжилсэн үзүүлэлтийн нэр, хэмжих нэгж *Test parameter, unit* | Шаардлага *Test specification, unit* | Шинжилгээний дүн *Test results* |
|---|---|---|---|---|
| | MNS 6341:2012 | Clostridium perfringens | - | >0.1 |
| | MNS 6341:2012 | Эмгэгтөрөгч нян | 1 гр-д илрэхгүй | 1 гр-д илрээгүй |
| | MNS ISO 7890-3:2001 | Нитрат | <130.0, мг/л | 13,1 |
| | MNS ISO 10390:2001 | pH | - | 7,83 |
| | MNS 6271:2011 | Сульфат | <160.0, мг/л | 35,5 |
| | MNS 3675:1984 | Органик нүүрстөрөгч | -, % | 0,23 |
| | MNS 3675:1984 | Ялзмаг | -,% | 0,39 |
| 428 | MNS 6341:2012 | *ББЕТ* | - | 2,2*10^5 |
| | MNS 6341:2012 | Clostridium perfringens | - | 0,01 |
| | MNS 6341:2012 | Эмгэгтөрөгч нян | 1 гр-д илрэхгүй | 1 гр-д илрээгүй |
| | MNS ISO 7890-3:2001 | Нитрат | <130.0, мг/л | 11,1 |
| | MNS ISO 10390:2001 | pH | - | 7,91 |
| | MNS 6271:2011 | Сульфат | <160.0, мг/л | 30,9 |
| | MNS 3675:1984 | Органик нүүрстөрөгч | -,% | 0,24 |
| | MNS 3675:1984 | Ялзмаг | -,% | 0,48 |
| 429 | MNS 6341:2012 | *ББЕТ* | - | 1,6*10^5 |
| | MNS 6341:2012 | Clostridium perfringens | - | 0,01 |
| | MNS 6341:2012 | Эмгэгтөрөгч нян | 1 гр-д илрэхгүй | 1 гр-д илрээгүй |
| | MNS ISO 7890-3:2001 | Нитрат | <130.0, мг/л | 12,5 |
| | MNS ISO 10390:2001 | pH | - | 7,73 |
| | MNS 6271:2011 | Сульфат | <160.0, мг/л | 29,7 |
| | MNS 3675:1984 | Органик нүүрстөрөгч | -,% | 0,23 |
| | MNS 3675:1984 | Ялзмаг | -,% | 0,36 |

**Санал тайлбар:**
*Opinions and interpretation*

**БАТАЛСАН:** ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ: *Approved by* ............ гарын үсэг/signature/ /Х .АЛТАНЧИМЭГ/

Энэ шинжилгээний дүн нь зөвхөн шинжилгээ хийсэн дээжинд хамаарна.
Шинжилгээний дүнг лабораторийн зөвшөөрөлгүй хуулбарлахыг хориглоно.



Хууль зүйн сайдын 2016 оны
А/204 дүгээр тушаалаар батлав.

МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ
000208612

2008.06.10
/ Бүртгэсэн он,сар,өдөр /

9011156052
/ Хувийн хэргийн дугаар /

5235359
/ Регистрийн дугаар /

Мөнх ариун ундарга — Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

| Шийдвэр | 01 | 2008.06.09 |
|---|---|---|
| / шийдвэрийн нэр / | / дугаар / | / он, сар, өдөр / |

| / Код/ | / Үйл ажиллагааны чиглэл / |
|---|---|
| 55101 | Зочид буудлын үйлчилгээ |
| 56102 | Зоогийн газрын үйлчилгээ |
| 47990 | Худалдааны зуучлал |

| Хугацаагүй | 1 | 1,058.00 |
|---|---|---|
| / хугацаа / | / гишүүдийн тоо / | / хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр / |

Улаанбаатар, Баянгол, 3-р хороо, 65, 53 тоот, Утас1: 99099069, Утас2: , Факс:
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг/

МОНГОЛ УЛС

Улсын бүртгэлийн ерөнхий газар
Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар
/ Бүртгэсэн байгууллагын нэр /

Гэрчилгээ дахин олгосон 2020 он 06 сар 17 өдөр

**Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл**

| Д/д | Нэмэлт өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Ажилтан тэмдэг |
| 1 | Дашдулам овогтой Ариунцэцэг-г Захирал-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв. | 2008.06.10 | Б.Авирмэд |
| 2 | Дахин гэрчилгээ олгов. | 2020.06.17 | У.Мандахтуяа |
| 3 | 47990 Худалдааны зуучлал үйл ажиллагааг хассаныг бүртгэв.<br>46100 Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа үйл ажиллагаа шинээр бүртгэв. | 2022.04.11 | М.Монголжин |
| 4 | 82190 Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагаа шинээр бүртгэв.<br>49230 Авто машинаар ачаа тээвэрлэх үйл ажиллагаа шинээр бүртгэв.<br>46630 Барилгын материалын худалдаа үйл ажиллагаа шинээр бүртгэв. | 2022.12.21 | Н.Золжаргал |
| 5 | 49120 Төмөр замын тээвэр зуучлал /2023.03.02-2026.03.01/ үйл ажиллагаа шинээр бүртгэв. | 2023.07.21 | Н.Золжаргал |

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

МОНГОЛ УЛС ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А-27 тоот тушаалын хавсралт

**МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ НУТАГ ДЭВСГЭРТ ГАЗАР АШИГЛАХ**

# ГЭРЧИЛГЭЭ

Дугаар 2015/607

"Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай" Монгол улсын хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх заалтыг үндэслэн Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газраас Улаанбаатар аймаг /хот/ Налайх сум /дүүрэг/-ын нутагт орших Горхи- Тэрэлжийн БЦГ тусгай хамгаалалттай газар нутгийн Арагант нэртэй 1.0 га талбайг Аялал жуулчлал зорилгоор ашиглахыг "Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай" хуулинд заасан нөхцөл, журмын дагуу зөвшөөрч, энэхүү гэрчилгээг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын 9011156052/5235359 тоот гэрчилгээ /регистр/-тэй Мөнх ариун ундарга ХХК-д Тав жилийн хугацаагаар олгов.

Энэхүү гэрчилгээ нь газар ашиглалтанд оруулсан аливаа өөрчлөлт, сунгалтыг тэмдэглэх хавсралттай бөгөөд хавсралтгүй бол хүчин төгөлдөрт тооцогдохгүй.

БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ НУТГИЙН УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА Л.БАТСАНСАР

2015 оны 08 сарын 06 өдөр

0150607

**ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГТ ГАЗАР АШИГЛАХ 2015/607 ТООТ ГЭРЧИЛГЭЭНИЙ ХАВСРАЛТ**

/Гэрчилгээгүй бол хүчингүй/

**Хоёр. Гэрчилгээгээр олгогдсон талбайн булангийн цэгүүдийн солбицлууд**

| № | Анхны солбицлууд, үндэслэл | Өөрчлөгдсөн солбицлууд, үндэслэл |
|---|---|---|
| 1. | Талбайн анхны солбицлууд<br>1 107° 26' 49,490" E 47° 54' 21,745" N<br>2 107° 26' 49,903" E 47° 54' 23,356" N<br>3 107° 26' 51,612" E 47° 54' 23,805" N<br>4 107° 26' 53,544" E 47° 54' 23,908" N<br>5 107° 26' 53,578" E 47° 54' 24,637" N<br>6 107° 26' 55,767" E 47° 54' 25,109" N<br>7 107° 26' 55,872" E 47° 54' 24,960" N<br>8 107° 26' 56,189" E 47° 54' 24,906" N<br>9 107° 26' 56,250" E 47° 54' 24,423" N<br>10 107° 26' 55,923" E 47° 54' 24,360" N<br>11 107° 26' 55,699" E 47° 54' 23,103" N<br>12 107° 26' 54,710" E 47° 54' 23,124" N<br>13 107° 26' 54,538" E 47° 54' 22,545" N<br>14 107° 26' 55,157" E 47° 54' 22,401" N<br>15 107° 26' 54,609" E 47° 54' 20,989" N<br>9991,83 квадрат метр<br><br>Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн А/321 дугаар тушаал, Хамгаалалтын захиргааны 2018 оны 07 дугаар сарын 27-ний өдрийн №321 тоот саналыг үндэслэн эргэлтийн цэгт өөрчлөлт оруулав.<br><br>2018 оны 09 сарын 17-ны өдөр<br>Ой, ус, тусгай хамгаалалттай газрын кадастрийн хэлтсийн дарга: Н.БАТЗАЯА<br>2018 оны 09 сарын 17-ны өдөр<br>Ой, ус, тусгай хамгаалалттай газрын кадастрийн хэлтсийн мэргэжилтэн: Э.ЭРДЭНЭХҮҮ | Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны 05 дугаар сарын 29-ний А/455 дугаар тушаалыг үндэслэн газар ашиглах эрхийн хугацааг 2025 оны 08 дугаар сарын 05-ныг хүртэл сунгав.<br><br>ТХНУГ-ЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ<br>Э.САНСАРБАЯР<br>2020 оны 06 дугаар сарын 09 |

БАТЛАВ
НАЛАЙХ “ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ” ОНӨААТҮГ-ЫН ДАРГА Ц.ЭРБОЛ

УЛААНБААТАР ХОТ НАЛАЙХ ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ ОНӨААТҮГ 9021101209 ОЧУ0034 2601053

# ХОГ ХАЯГДЛЫГ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

2023 оны 04 сарын 10-ны өдөр №.................. Налайх дүүрэг

| | |
|---|---|
| Иргэн, ААНБ-ын нэр | Сац Мөнх Ариун Ундарга |
| Регистрийн дугаар | 5235959 |
| Үйл ажиллагаа явуулж буй объектын оноосон нэр: | Сац |
| Үйл ажиллагааны чиглэл | Жуулчны бааз |
| Иргэн, ААНБ-ын хаяг | 6р хороо Арганатын ам |
| ААНБ-ын холбогдох утас | |
| Газар зүйн хязгаарлалт | Налайх дүүргийн .......6....... хороо |
| Данс:5749062084 | Хаан банк |
| Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төрөл | агилшаар |
| Төлбөрийн нөхцөл | дансаар |
| Гэрээний хугацаа | 2023.04.10 - 2023.09.10. |

Энэхүү гэрээ нь Монгол Улсын хог хаягдлын тухай (шинэчилсэн найруулга) хууль, Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах, ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг цуглуулах, хадгалах, тээвэрлэх харилцааг зохицуулах, аж ахуйн нэгж байгууллага, ХХЭрхлэгч нэг бүрийн үүрэг хариуцлагыг тодорхойлж дүгнэх, Эрүүл ахуйн тухай хууль, Нийслэлийн ИТХ-ийнТэргүүлэгчдийн 2009 оны 63-р тогтоолоор батлагдсан “Хот тохижилт,цэвэрлэгээний талаар албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн дагаж мөрдөх журам”,”Журамд өөрчлөлт оруулах тухай” Нийслэлийн ИТХ-ийн 2012 оны **61**-р тогтоол, Налайх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 19/04 дугаар тогтоол болон бусад холбогдох хууль тогтоомжийг үндэслэн баримтална.

Нэг талаас Налайх дүүргийн Тохижилт Үйлчилгээ ОНӨААТҮГ /цаашид “хог хаягдал тээвэрлэгч” гэх/ нөгөө талаас /..............Сац мөнх ариун ундарга............../
/иргэн, аж ахуй нэгж байгууллагын нэр/

Төлөөлж /цаашид “Хог хаягдал “тээвэрлүүлэгч” гэх ....нягтлан бодогч.... ажилтай .....Батмөнх..... овогтой .....Буянхишиг..... нар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү гэрээ нь Налайх дүүргийн ......6....-р хорооны нийтийн эзэмшлийн зам талбай, айл өрх, аж ахуй нэгж байгууллагын хог хаягдлыг цуглуулж, ачиж тээвэрлэн төвлөрсөн хогийн цэгт хүргэж хариуцсан бүсийг хог хаягдалгүй цэвэр байлгахад оршино.

1.2. Энэхүү гэрээнд зохицуулагдаагүй харилцааг Монгол Улсын “Иргэний хууль” Монгол Улсын Хог хаягдлын тухай хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулна.

1.3. Их цэвэрлэгээ болон бусад хог хаягдлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр хороо болон бусад төрийн байгууллагатай хамтран ажиллана.

## ХОЁР. ХОГ ТЭЭВЭРЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

2.1. Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх чиглэл хуваарийг тогтоож ажиллана

2.2. Хог хаягдлыг зориулалтын битүүмжлэлтэй ажилгүй ажиллагааны шаардлага хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

2.3. Хог хаягдлыг тээвэрлэх тээврийн хэрэгслийн жолооч, ачигч нар нь зохих сургалтад хамрагдах аюулгүй ажиллагааны шаардлага хангаж ажиллана.

2.4. Хог хаягдлыг цуглуулах тээвэрлэх үед унах, асгарах, хийсэхээс сэргийлэх арга хэмжээ авна.

2.5. Овор хэмжээ ихтэй болон барилгын хог хаягдлыг ачиж тээвэрлэхдээ үйлчилгээний хөлс авч үйлчилнэ.

2.6. Хог хаягдлын тухай хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт болон энэхүү гэрээний 3.3, 3.8 дахь заалтын хэрэгжилтэд хяналт тавьж хангалтгүй биелүүлсэн тохиолдолд шаардлага хүргүүлнэ.

## ГУРАВ. ХОГ ТЭЭВЭРЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Хог тээврийн үйлчилгээний гэрээний төсөлтэй танилцаж, хог хаягдлын тухай хуулийн 10.2.3-д заасны дагуу гэрээ байгуулах

3.2. Хог хаягдлын тухай хууль түүнтэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт болон энэ гэрээний 2.2-2.6 дахь заалтын хэрэгжилтэд хяналт тавьж, хангалтгүй биелүүлсэн тохиолдолд шаардлага тавих эрхтэй.

3.3. Хог хаягдлыг ангилах, ачих цуглуулах технологид нийцсэн, галд тэсвэртэй материалаар хийгдсэн, хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн хогийн савтай байх ба хогийн саванд жилд ...... удаа холбогдох тусгай зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуй нэгж байгууллагаар ариутгал хийлгэж, ариутгал хийлгэсэн талаар тээвэрлэгч байгууллага болон мэргэжлийн холбогдох байгууллагад мэдэгдэх.

3.4. Хог хаягдлын талаарх сургалтад хамрагдах

3.5. Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх аваагүй аж ахуй нэгж, байгууллагаас хог хаягдал цуглуулах, тээвэрлэх үйлчилгээ авахыг хориглоно.

3.6. Хог хаягдлыг зориулалтын хогийн сав болон цэгээс хүлээлгэн өгөх ба авах хуваарийн дагуу ачих үед саадгүй тээвэрлэх нөхцөлийг бүрдүүлнэ. Хөлдүү болон нурам үүссэн хогийг захиалагч өөрөө хариуцаж савлаж, унтрааж, хогийн сав болон орчноос бүрэн суллаж ачихад бэлтгэнэ.

3.7. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас үйл ажиллагаа явуулах боломжгүй болон тохиолдолд үйл ажиллагаа явуулах хугацааг урьдчилан мэдэгдэж хуваарьт өөрчлөлт оруулах хүсэлтийг бичгээр гарган нягтлан бодогчид өгнө.

3.8. Овор хэмжээ ихтэй болон барилгын хог хаягдлыг тээвэрлэгч байгууллагад шилжүүлнэ.

## ДӨРӨВ. ТӨЛБӨР ТООЦОО

4.1. Монгол Улсын “Хог хаягдлын тухай (шинэчилсэн найруулга)” хуулийн 41 дүгээр зүйлийг үндэслэн хог хаягдал гарган төлбөрийг Налайх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 19/04 дугаар тогтоолоор батлагдсан төлбөрийн хэмжээгээр ......200,000......... төгрөгийг сар бүрийн ...ажил... өдрийн дотор Хаан банк 5749062084 тоот дансанд аж ахуй нэгжийн нэр, утасны дугаар, хаягийг бичиж хугацаанд бүрэн төлнө.

4.2. овор хэмжээ ихтэй болон барилгын хог хаягдлыг тээвэрлэх үйлчилгээний хөлс нь хог хаягдлын үйлчилгээний хураамжид хамаарахгүй. Үйлчилгээний хөлсийг гэрээгээр тохиролцсоны дагуу төлнө.

4.3. Төлбөр хураамжид өөрчлөлт орсон тохиолдолд тухайн гэрээнд өөрчлөлт хийнэ.

## ТАВ. ТАЛУУДЫН ХАРИУЦЛАГА

5.1. Талууд гэрээний биелэлтийг хагас бүтэн жилээр дүгнэж, цаашид илүү үр дүнтэй хамтран ажиллах боломжийг тодорхойлж тооцоо нийлнэ.

5.2. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй эсвэл зохих ёсоор биелүүлээгүй бол Хог хаягдлын тухай хууль болон Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээнэ.

## ЗУРГАА. ДАВТАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

6.1. Энэхүү гэрээг гүйцэтгэх нөлөөлөх давтагдашгүй хүчин зүйлийн нөхцөл / үер ус, газар хөдлөлт, гал түймэр, нийтийг хамарсан үймээн самуун гэх мэт онц байдлын нөхцөлүүд/ үүсэн тохиолдолд талууд гэрээний үүргээсээ татгалзах эрхтэй ба гэрээний талууд учирсан хохирлыг төлөхийг шаардах эрхгүй.

## ДОЛОО. БУСАД

7.1. Талууд энэхүү гэрээнд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

7.2. Талууд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно. Гэрээний нэмэлт өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Гэрээний нэмэлт өөрчлөлт нь талуудын эрх тэгш байдал болон гэрээний чөлөөт байдлын зарчим дээр харилцан тохиролцсоны үндсэн дээр хийгдэнэ.

7.3. Энэхүү гэрээ нь Монгол хэлээр 2 ижил хувь хийгдэх бөгөөд нэг хувийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, нөгөө хувийг Налайх Тохижилт Үйлчилгээ ОНӨААТҮГ тус тус хадгална.

## ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

| Тээвэрлэгчийг төлөөлж: | Тээвэрлүүлэгчийг төлөөлж” |
|---|---|
| Налайх “Тохижилт Үйлчилгээ” | ......Мөнх ариун ундарга...... ХХК-ий |
| ОНӨААТҮГ-ыг ......түгээх поош...... ажилтай | ......менежер...... ажилтай |
| ....................../ Т. Ариунжаргал / | ....................../ Б.Буянхишиг / |
| Утасны дугаар : 85777703 | Утасны дугаар : 99665797 |

5235359 ХАК5809 МӨНХ АРИУН УНДАРГА ХХК УЛААНБААТАР ХОТ

БАТЛАВ.
ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ДАРГА
Ц. АЛТАНЦООЖ

БАТЛАВ.
“ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ” ОНӨААТҮГ-ЫН ДАРГА
Д. ЭРБОЛ

БАТЛАВ.
Сац Мөнх Ариун Ундарга
1Д. Ариунцэцэг

## ХУРААМЖ ТӨВЛӨРҮҮЛЭХ ГЭРЭЭ

2023 оны .04 сарын ...10 өдөр №__ Налайх дүүрэг

### НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах, ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг цуглуулах, хадгалах, тээвэрлэх харилцааг зохицуулах, аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгч нэг бүрийн үүрэг хариуцлагыг тодорхойлж дүгнэх, Нийслэлийн ИТХ-ийн Тэргүүлэгчдийн 2009 оны 63-р тогтоолоор батлагдсан “Хот тохижилт, цэвэрлэгээний талаар албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн дагаж мөрдөх журам”,”Журамд өөрчлөлт оруулах тухай” Налайх дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн “Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэм хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолыг хэрэгжүүлэхэд энэхүү гэрээний зорилго оршино.

Энэхүү гэрээг нэг талаас Татварын хэлтэс, Налайх Тохижилт Үйлчилгээ ОНӨААТҮГ-ыг төлөөлж ....Д. Ариунтамир...., аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчийг төлөөлж ....6р хороо Ананторх ам.... хаягтай, ....5285359.... регистрийн дугаартай ....Сац Мөнх Ариун Ундарга....ХХК, иргэн/ бид харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

### НЭГ: “ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ” ОНӨААТҮГ-ЫН ЭРХ, ҮҮРЭГ

1.1 Аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн хог хаягдлыг тээвэрлэхдээ хог хаягдлын хураамжийг төсөвт төлсний дараа сард нэг удаа өөрийн тээврийн хэрэгслээрээ тээвэрлэнэ.
1.2 Татварын хэлтэстэй хамтран хог хаягдлын гэрээг аж ахуйн нэгж, иргэдтэй жил бүр байгуулна.
1.3 Аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хог тээврийн үйлчилгээг батлагдсан хуваарийн дагуу бүрэн хариуцаж тээвэрлэнэ.
1.4 Хог тээвэрлэлтийн талаарх санал гомдлыг хүлээн авч тухай бүр нь шуурхай шийдвэрлэнэ.
1.5 Тээвэрлэгч байгууллага нь Татварын хэлтэстэй тооцоо нийлсний үндсэн дээр хог хаягдлын хураамжаа 3 сараас дээш төлөөгүй аж ахуйн нэгж, иргэдийн хогийг тээвэрлэхгүй.

### ХОЁР. ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ЭРХ, ҮҮРЭГ

2.1 Татварын хууль тогтоомжийн дагуу сар бүрийн 25-ны өдрийн дотор гэрээнд заасан үйлчилгээний хураамжийн дүнгээр хураан төвлөрүүлнэ.
2.2 Аж ахуй нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн авлага, өглөгийн мэдээг сар бүр гаргаж Налайх Тохижилт Үйлчилгээ ОНӨААТҮГ-т хүргүүлэн тооцоо нийлнэ.
2.3 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах эрхийг цуцлуулах хүртэлх саналыг холбогдох байгууллагууд хүргүүлнэ.

### ГУРАВ: ГЭРЭЭТ АЖ АХУЙН НЭГЖИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1 Налайх дүүргийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 19/04 дугаар тогтоолын дагуу 160,000 төгрөгийн үйлчилгээний хөлс сар бүр төлнө.
3.2 Хог хаягдлыг агуулах тусгай тагтай савтай байх, машин очсон тохиолдолд хогоо гаргаж асгаж байх, ил задгай асгах шатаах зэргээр орчин бохирдуулахгүй байх.
3.3 Дүүргийн ЗДТГ-аас хариуцуулсан болон өөрийн орчны газрынхаа хог хаягдлыг байнга цэвэрлэх болон хог хаягдлыг зайлуулах олон нийтийн ажилд оролцож байх.
3.4 Хог тээвэрлэлтийн талаарх санал гомдлоо холбогдох байгууллагуудад гаргаж шийдвэрлүүлэх.
3.5 Барилгын хатуу хог хаягдал бусад төлбөрт үйлчилгээг нэмэлт захиалга үйлчилгээ авах Налайх тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 70232219 захилга өнгө.

## ДӨРӨВ: ТӨЛБӨР ТООЦОО

4.1 Эрх зүйн баримт бичиг стандарт, үнэ тарифд өөрчлөлт орсон тухай бүр гэрээ шинэчлэн байгуулна.
4.2 Аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгч нь үйл ажиллагаа явуулаагүй тохиолдолд холбогдох Татварын хэлтэс, Налайх тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-т мэдээлж, нотлох бичиг баримтыг Татварын хэлтэст ирүүлэнэ.
4.3 Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг Налайх дүүргийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 19/04 дугаар тогтоолын дагуу гэрээнд заасан үйлчилгээний хөлсийг сар бүр нэхэмжлэлийн дагуу төлнө.

## ТАВ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

5.1 Эхлэх хугацаа 2023 оны 04 сарын 20 ны өдөр
Дуусах хугацаа 2024 оны 04 сарын 10 ны өдөр

## ЗУРГАА:ГЭРЭЭНИЙ ХАРИУЦЛАГА.

6.1 Энэхүү гэрээтэй холбоотой гарсан маргааныг харилцан тохиролцох бөгөөд шийдвэрлэж чадахгүй нөхцөлд холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.
6.2 Гэрээний биелэлт дээр Татварын хэлтэс, Налайх тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ, үйлчлүүлэгч харилцан хяналт тавьж ажиллана.
6.3 Хог тээврийн гэрээ байгуулаагүй, зориулалтын бус газар хог хаягдал хаясан аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчийг Хог хаягдлын тухай хуулийн 22.4.2 дугаар заалтын дагуу 150000-250000 төгрөгөөр торгоно.

ГЭРЭЭ ХИЙСЭН.

| ТАТВАРЫН ХЭЛТСИЙГ ТӨЛӨӨЛЖ | ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ ОНӨААТҮГ-ЫГ ТӨЛӨӨЛЖ | ТӨЛӨӨЛЖ |
|---|---|---|
| / / | / Г. Энхтайван / | / / |
| Утасны дугаар:70232681 | Утасны дугаар:70232219 | Утасны дугаар: 91771111 |

УСНЫ МЭДЭЭЛЛИЙН САН

Байгаль орчны Сайдын
2004 оны 185 тоот
тушаалаар батлав.

# ӨРӨМДМӨЛ ХУДГИЙН ТЕХНИКИЙН ПАСПОРТ

ЭНЭХҮҮ ПАСПОРТЫГ ХУДАГ ЭЗЭМШИГЧ ӨМЧИЛНӨ

Сум, дүүрэг, хороо ...УБ, Налайх 6-р хороо...

Эзэмшигч иргэн, байгууллагын нэр ...Мөнх ариун ундарга ХХК

Өрөмдмөл худгийн нэр ......................

Улсын № 11000-12600-12710-03637

Байршиж буй газрын нэр, хаяг ......................
...Тэрэлж...

Усны ашиглах гэрээний №

Ус ашиглах эрхийн бичгийн нэр №

Худаг гаргасан (аж ахуйн нэгж) ...“Эрдэнэдриллинг” ХХК

Тамга

Захирал ...[signature] Б. Шижирмаа

201 6 он 8 сар 29 өдөр

Баталгаажуулсан:

...Нийслэл... аймаг (нийслэл)-ийн Байгаль орчны албаны

тамга

Дарга ...[signature]...

201 7 он 07 сар 27 өдөр

4

## Худгийн байршлын солбицол

Уртраг: ...47°54'23.80"N

Өргөрөг: ...107°26'53.73"E

Үнэмлэхүй өндөр: ......................м,

Аймгийн код Сумын код Худгийн зориулалтын код

| Аймгийн код | Сумын код | Худгийн зориулалтын код |
| --- | --- | --- |
| 11000 | 12600 | 6 |

...Улаанбаатар...аймгийн, хотын ...НД 6-р... сумын

дүүргийн, хорооны, багийн ...Тэрэлж... гэдэг газарт,

...Уус ахуйн хэрэгцээ...-д зориулан.

(усжуулалт, усан хангамж г.м)

...Улаанбаатар... аймгийн, (хотын)

...Эрдэнэдриллинг...компаний ...Дамбадорж...менежер

ахлагчтай анги, бригад ...Супер-6000... маркийн

станокоор ...Хиймэл уусгалт... аргаар уул

худгийн цооногийг 201 6 он 8 сарын 17-едрөөс 20 16 он

8 сарын 18 өдөр хүртэл өрөмдөж гаргав.

5

## I. ЦООНОГИЙН БҮТЭЦ ЗОХИОМЖ

1. Цооногийн гүн ..........62.......... м
2. Усны тогтсон түвшин (статик) ..........15.......... м
3. Цооногийн ашиглалтын усны ундарга ..........1.5.......... л.с
4. Цооногийн өрөмдсөн диаметр
   ..........0.......... м-ээс ..........62.......... м хүртэл ..........159.......... мм
   .......... м-ээс .......... м хүртэл .......... мм
   .......... м-ээс .......... м хүртэл .......... мм
5. Уст үеийн байрлал:
   Нэгдүгээр үе ..........24.......... м-ээс ..........25.......... м
   Хоёрдугаар үе ..........48.......... м-ээс ..........49.......... м
   Гуравдугаар үе .......... м-ээс .......... м
6. Цооногийн бэхэлсэн суултын яндан:
   Диаметр = ..........159.......... мм ..........0.......... м-ээс ..........6.......... м
   Диаметр = .......... мм .......... м-ээс .......... м
   Диаметр = .......... мм .......... м-ээс .......... м
7. Шүүхийн хийц зохиомж:
   Шүүрийн яндангийн нүхний диаметр ..........20x1.......... мм
   1 уртааш м-т оногдох нүхний тоо ..........8.......... ширхэг
   Шүүрийн диаметр ..........100.......... мм
   Шүүрийг ороосон утасны диаметр ..........1x1.......... мм
   Шүүрийг ороосон торны ..........
   Шүүрийн яндангийн нийт урт ..........62..........м



Үүнд:

Шүүрийн дээд хэсгийн урт ..........24.......... м, ..........0.......... м-ээс ..........24.......... м
Ажлын хэсгийн урт ..........4.......... м, ..........24.......... м-ээс ..........28.......... м
Дүлий хэсгийн урт ..........8.......... м, ..........28.......... м-ээс ..........36..........м
Ажлын хэсгийн урт ..........4.......... м, ..........36.......... м-ээс ..........40..........м
Дүлий хэсгийн урт ..........4.......... м, ..........40.......... м-ээс ..........44.......... м
Тунгаагчийн урт ..........4.......... м, ..........44.......... м-ээс ..........48..........м
14 48 62

8. Яндангийн араар дүүргэсэн хайрга
9. Цооногт .......... м-ээс ..........м хүртэл
   .......... м-ээс ..........м хүртэл
   цементац (тампонаж) хийв.
10. Шавхалтыг 201 6.. он ..8.. сарын ..18.. өдрийн ..15.. цагаас ....8.... сарын ..18.. өдрийн ..16.. цаг хүртэл ....1.... цаг хийв.
    Шавхалтыг ..QJD.... маркийн насосаар ..........55..........м
    гүнд насосыг суулгаж ..........Атлас копко.......... маркийн
    компрессороор .......... м ус өргүүр яндангг ..........62..........м
    гүнд суулгаж .......... м хий дамжуулах яндангг ..........м,
    усны түвшин хэмжигч яндангг ..........м
    гүнд тус тус суулгаж гүйцэтгэв.
    Шавхалт хийхэд усны
    I. Түвшин бууралт .......... метр ундарга ..........1.5..........л/с
    II. Түвшин бууралт .......... метр ундарга ..........л/с
    III. Түвшин бууралт .......... метр ундарга ..........л/с
    тус тус байв.

## II. ЦООНОГИЙН ЗҮСЭЛТ

| Масштаб см:м | Үеийн ул хүртэлх гүн (м) | Геологийн зүсэлт | Чулуулгийн бичлэг геологийн насны индекс | Хийц зохиомж | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Суултан шүүрийн яндангийн байрлал | Суулгасан гүн,м |
| | 0-3 | [illegible] | [illegible] хөрс | | |
| | 3-6 | + + + + + | Огорцон боржин | | |
| | 6-24 | + + + | Боржин | | |
| | 24-25 | — • ▼ | Уст үе | | |
| | 25-48 | + + + | Боржин | | |
| | 48-49 | — • ▼ | Уст үе | | |
| | 49-62 | + + + + + | Боржин | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |



## III. ЦООНОГИЙН УСНЫ ЧАНАР

1. Шинжилгээ хийсэн он, сар, өдөр ....................................

| Үзүүлэлтүүд | Уст үеийн № ба интервал | | |
|---|---|---|---|
| | № ...............м | № ...............м | № ...............м |
| Дээж авсан | | | |
| Лабораторт өгсөн | | | |

2. Физикийн шинж чанар

| Үзүүлэлтүүд | Уст үеийн № ба интервал | | |
|---|---|---|---|
| | № ...............м | № ...............м | № ...............м |
| Өнгө | | | |
| Үнэр | | | |
| Амт | | | |
| Тунгалаг чанар | | | |
| Тунадас | | | |
| Булингар | | | |
| Температур °С | | | |

3. Химийн найрлага:

| Үзүүлэлтүүд | Нэгж хэмжээ | Уст үеийн № ба интервал | | |
|---|---|---|---|---|
| | | № ...........м | № ...........м | № ...........м |
| PH (идэвхит урвал) | | | | |
| $CO_2$(чөлөөт) | мг/л | | | |
| $CO_2$(түрэмгий) | " | | | |
| $H_2S$ (хүхэрт устөрөгч) | " | | | |
| $SiO_2$(цахиурын 2т исэл) | " | | | |
| Исэлдэх чанар $O_2$ | " | | | |
| Хуурай үлдэгдэл 180°С | " | | | |
| Ерөнхий хатуу | мг, экв/л | | | |
| Арилгах хатуу | " | | | |
| Тогтмол хатуу | " | | | |

## IV. ХУДГИЙН БАРИЛГА ТӨХӨӨРӨМЖ

1. Худагт ......QJD 0,75 кВт 3 тн......... маркийн ус өргөгч, .......................................................... маркийн хөдөлгүүр тавив.

Насосыг ..............55.............................м гүнд байрлуулав.

Ус өргөгч яндангийн диаметр .........32...... мм, урт нь ......55.....м

Насосын штангийн диаметр .......................мм, урт нь ............м

Ус өргөгч төхөөрөмжийг угсарсны дараа ..............1.............. цаг зүгшрүүлэх шавхалт хийхэд усны ундарга ...........1,5.........л/сек болов.

2. Насос станцын барилгын нийт талбай ....................................м²

3. Усны резервуарын багтаамж ...............................................м³ хийсэн материал ......................................................................



## V. ХУДГИЙН ӨРТӨГ

1. Өрөмдлөгийн үнэ ............................................ төг
2. Насрс станцын барилгын үнэ ........................... төг
3. Тоног төхөөрөмжийн үнэ .................................. төг

Бүгд ................................ төг

Өрөмдмэлъхудгийг 201..... оны ..... сарын .... өдөр ..... тоот актаар комиссын дарга ........................................................ гишүүд ........................................................................................... ...........................................................................................нарын бүрэлдэхүүнтэй комисс ............ иргэн, компани, байгууллагын нэрийн өмнөөс ашиглалтад хүлээлцүүлэв.

Паспортыг хөтөлсөн:

..........Менежер..........албан тушаалтай

..........[signature]..........(Д.Баянбаатар)

№ 2996

**УС ХЭРЭГЛЭГЧИД ЦООНОГ ӨРӨМДӨХ ЗӨВШӨӨРЛИЙН ХУУДАС**

*2016 оны 08-р сарын 17 өдөр* **Дугаар 617**

1. **ЗАХИАЛАГЧ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, ИРГЭНИЙ НЭР:** *"Мөнх ариун ундарга" ХХК*
2. **ХАРИУЦАН ГҮЙЦЭТГЭГЧ:** *"Эрдэнэдриллинг" ХХК*
3. **ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ГАЗРЫН БАЙРШИЛ:** *Налайх дүүргийн 6 дугаар хороо, Тэрэлжийн Арагантын ам, 47°54'23.80"N, 107°26'53.73"E*
4. **БАЙГАЛЬТАЙ ХАРЬЦАХ ХЭЛБЭР:** *Цооног өрөмдөх*
5. **ӨРӨМДӨХ МАШИН, ТЕХНИК ХЭРЭГСЭЛ:** *Супер-6000 маркын өрөм*
6. **ХЭРЭГЖҮҮЛЭХ БОЛЗОЛ НӨХЦӨЛ:**

*а/ Цооногийн байршлыг сонгохдоо усны эрүүл ахуйн болон хамгаалалтын бүс байгуулах боломжийг бүрдүүлэх*

*б/ Өрөмдлөгийн техник аюулгүй байдлыг хангах*

*в/ Өрөмдлөгийн дүнд усны боломжтой нөөц илэрч худаг болгон ашиглах тохиолдолд ус ашиглах зөвшөөрлийг зохих журмын дагуу авах*

*г/ Усны хими-бактерлогийн шинжилгээ хийлгэх*

*д/ Ус ашиглах гэрээ байгуулж ажиллах*

*е/ Ус ашиглагч нь усны нөөц ашигласны төлбөр хураамжийг бүрэн гүйцэт хугацаанд нь төлж байх*

*ё/ Цооногийг худаг болгон ашиглахын өмнө худгийн техникийн паспортыг Нийслэлийн Байгаль орчин, ногоон хөгжлийн газраас авч хөтлөх*

7. **БАЙГАЛЬТАЙ ХАРЬЦАХАД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ:**

*а/ Цооног өрөмдөж байгаа газарт цацраг идэвхт, халдвар тараах болон химийн хорт бодисын хаягдал хадгалах, устгах, хог хаягдал, бохирдуулах бодис, үйлдвэрийн болон ахуйн бохир ус хаях, орчин бохирдуулахыг хориглоно.*

*б/ Зөвшөөрөл авснаас өөр газарт шилжүүлэн цооног ухахыг хориглоно.*

*в/ Цооногийг ашиглахгүй тохиолдолд битүүмжлэн Нийслэлийн Байгаль орчин ногоон хөгжлийн газарт хүлээлгэн өгнө.*

**ЦООНОГ ГАРГАХ ГҮН:** *80 М*

**ТЭМДЭГТИЙН ХУРААМЖ:** *150 000 төгрөг*

**ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОСОН:**
**НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН ДАРГА** **Х.МАРАТ**


Мөнх ариун ундарга ХХК
Image © 2016 CNES / Astrium
Google earth

## УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2023 оны 06 дугаар сарын 08 Дугаар 2023/15 Налайх дүүрэг

**Нэг. Ерөнхий зүйл**

Налайх дүүргийн Засаг даргын 2018 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн ус ашиглах зөвшөөрөл, Нийслэлийн Байгаль орчны газрын даргын олгосон 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 2023/28 дугаартай ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн: **Ус ашиглуулагчийг төлөөлж**: Налайх дүүргийн Засаг даргын орлогч Н.Мандуул, **Ус ашиглагчийг төлөөлж**: Нийслэлийн Налайх дүүрэг 6 дугаар хороо, 9011156052 дугаартай улсын бүртгэлийн гэрчилгээтэй, 5235359 регистрийн дугаартай **“**Мөнх ариун ундарга” ХХК-ийг төлөөлж захирал Д.Ариунцэцэг нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 08-ны өдрийг дуустал 1 жилийн хугацаатайгаар байгуулав.

**Хоёр. Гэрээний гол нөхцөл:**

2.1. **Ус ашиглах зориулалт:** Унд ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар гүний худгаас усыг авч ашиглана.

2.2. **Ашиглах усны хэмжээ:**

2.2.1. **Унд- ахуй, $м^3$/жил**..........................................**10643.4 $м^3$**...............................................

2.2.2.**үйлдвэрлэл, үйлчилгээ $м^3$/ жил**.....................................................................................

2.2.3. **Зүлэг талбайн усалгаа $м^3$/ жил** ......................................................................................

2.2.4. эмчилгээ, сувилгаа, хүн/ хоног .........-..................................................................................

2.3. **Усны чанар, найрлага:** ......................................-...............................................................

2.4. Усны эх үүсвэрийн :

**Байршил:** Налайх дүүрэг 6 дугаар хороо

**Солбилцол**: 47°54'23.80"N, 107°26'53.73"E

**Барилга байгууламж:** Гүний худгаас өөр усны барилга байгууламж байхгүй.

**Тоног төхөөрөмжийн нэр, марк**: Худагт QJD 0.75м2 3 тн ус өргөгч насосыг 55 метрийн гүнд байрлуулсан. 0010005061 дугаартай LXSG-25 загварын усны тоолуур суурилуулсан. 2023 оны 4-р сарын байдлаар тоолуурын заалт 03831м3.

**Хүчин чадал**:

2.5. Хаягдал усны:

**Хэмжээ:** Жуулчны баазын барилгууд нь хоорондоо цэвэр, бохир усны шугамаар холбогдсон. Гэр буудлууд нийтийн ариун цэврийн өрөөтэй. Жуулчны бааз нь 140 хүн хүлээн авахад тохирсон ХБНГУ-ын BUSSE MBR компанийн бага оврын цэвэрлэх байгууламжийг барьж ашиглалтад оруулсан.

**Стандартын шаардлага:** ....................................

**Хаях цэгийн байршил:**

**Солбилцол:** 47°54'23.80"N, 107°26'53.73"E

2.6. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ. Усны биохимийн шинжилгээний дүнг хавсаргана.

Жинлэгдэх бодис, кг .................................-...................................................................

Органик бодис, кг .....................................-...................................................................

Эрдэс бодис, кг .........................................-...................................................................

Хүнд метал, кг ..........................................-...................................................................

Аюултай бохирдуулах бодис, бодис, гр ................................-.........................................

**2.7 Бохир ус цэвэрлэх барилга байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх арга, цэвэрлэгээний түвшин:** Жуулчны баазаас гарсан ахуйн бохир усыг мембран биориакторын аргаар 99.97% хүртэл цэвэрлэх боломжтой.

**2.8. Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ:**
**2.9. Усны тоолуурын төрөл нэр дугаар:**
**Төрөл, нэр, дугаар:**
**Загвар** .........................................................................................................................................
**Тоолуурын тоо:** .............................................................................................................................
**Суурилуулсан байгууллага, огноо:**
**Тоолуурын заалт**:
**2.10. Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ:** 2023 оны ус ашиглах дүгнэлтээр үйлчилгээний ус ашиглалтад **10643.4 м$^3$** ус, автоклавт ус ашиглах тооцоо гарсан бөгөөд усны төлбөрийг “Усны экологи, эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 302 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, “Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай” Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоол, “Тогтоолын хавсралтанд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын засгийн газрын 327 дугаар тогтоолын дагуу усны төлбөрийг усны тоолуурын заалтаар 2023 оны **12** дугаар сарын **25**-ны дотор Налайх дүүргийн Татварын хэлтсийн **Хаан банкны 5749922224** дугаартай дансанд төвлөрүүлнэ.
**2.11. Хаягдал усан дахь нэгж бохирдуулах бодист ногдох төлбөрийн хэмжээ:** ......-.....

**Гурав. Талуудын эрх, үүрэг**

Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 10.1.18, 13.1.1, 13.1.5, 18.1.4, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 30.2, 31.1-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

**Дөрөв. Бусад**

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаарх дүгнэлт, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.
4.3. Гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ.
4.4. Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.
4.5. Гэрээг дор дурдсан үндэслэлээр хугацаанаас нь өмнө цуцалж болно.
4.5.1. ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн;
4.5.2 аль нэг тал татан буугдсан бол.
4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| Ус ашиглуулагчийг төлөөлж: | Ус ашиглагчийг төлөөлж: |
|---|---|
| Налайх дүүргийн Засаг даргын орлогч Н.Мандуул | “Мөнх ариун ундарга” ХХК-ийн захирал Д.Ариунцэцэг |
| 2023 оны 06 сарын 10 | 2023 оны 06 сарын 10 |

МӨНХ АРИУН УНДАРГА ХХК
5226569 ХАК5809
УЛААНБААТАР ХОТ

БАТЛАВ

НАЛАЙХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ

Н.МАНДУУЛ

БАТЛАВ

“МӨНХ АРИУН УНДАРГА” ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Д.АРИУНЦЭЦЭГ

## ХАЯГДАЛ УСЫГ БАЙГАЛЬД ШУУД НИЙЛҮҮЛЖ БАЙГАА ХУУЛИЙН ЭТГЭЭДТЭЙ БАЙГУУЛАХ УС БОХИРДУУЛСНЫ ТӨЛБӨРИЙН ГЭРЭЭ

2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр № 05 Налайх дүүрэг

### Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасны дагуу Туул голын сав газрын захиргааны гаргасан 2023 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн ХУД 23/45 дугаартай хаягдал ус хаях, зайлуулах дүгнэлтийг үндэслэн Нэг талаас: Ус ашиглуулагчийг төлөөлж дүүргийн Засаг даргын орлогч Н.Мандуул, нөгөө талаас ус бохирдуулагчийг төлөөлж Улаанбаатар хотын Налайх дүүргийн 6 дугаар хороо байрлах 9011156052 тоот улсын бүртгэлийн гэрчилгээ, 5235359 тоот регистрийн дугаартай “МӨНХ АРИУН УНДАРГА” ХХК-ийг төлөөлж захирал албан тушаалтан Д.АРИУНЦЭЦЭГ нар ус бохирдуулсаны төлбөр, нөхөн төлбөр төлөх талаар харилцан тохиролцон энэхүү гэрээг 1 /нэг/ жилийн хугацаатай байгуулав.

### Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. Ус бохирдуулагч нь хаягдал усыг “Хүрээлэн байгаа орчин, Усны чанар. Хаягдал ус Ерөнхий шаардлага” MNS 4943:2015 стандартын норматив шаардлагад нийцүүлэн байгальд шууд нийлүүлнэ.

2.2. Ус бохирдуулагч нь Усны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасны дагуу хаягдал усны чанарыг энэхүү гэрээний 2.1-д заасан стандартын норматив шаардлагад нийцүүлсэн тохиолдолд ус бохирдуулсны төлбөр, стандартын норматив шаардлагад нийцүүлээгүй тохиолдолд ус бохирдуулсны нөхөн төлбөрийг хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын хэмжээнээс хамааран 2-5 дахин шатлан өсгөх хэлбэрээр тооцож төлнө.

2.3. Төлбөр төлөгч нь Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасны дагуу хаягдал усан дахь бохирдуулах бодист ногдох төлбөр, нөхөн төлбөрийг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор харьяалах татварын албанд төлнө.

2.4. Ус бохирдуулагч нь дараах мэдээллийг улирал тутамд Сав газрын захиргаа, харьяа татварын албанд хүргүүлнэ. Үүнд:

2.4.1. Хаягдал ус нийлүүлдэг хүн, хуулийн этгээдийн нэр,

2.4.2. Цэвэрлэх байгууламж болон зөөврийн машинд нийлүүлсэн хаягдал усны хэмжээ,

2.4.3. Байгальд нийлүүлсэн хаягдал усны хэмжээ,

2.4.4. Хаягдал усанд байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор хийлгэсэн шинжилгээний дүн,

2.4.5. Ус бохирдуулсны төлбөр төлсөн тайлан.

### Гурав. Ус ашиглуулагчийн эрх, үүрэг

3.1. Ус бохирдуулагчийг мэдээ, мэдээлэл, мэргэжил аргазүйн удирдлагаар хангаж, хяналт тавина.

3.2. Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.8 дахь заалтад заасны дагуу Сав газрын захиргааны дүгнэлтийг үндэслэн Усны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх

заалтад заасны дагуу Сум, дүүргийн Засаг дарга нь нутаг дэвсгэртээ хаягдал ус зайлуулах цэг тогтооно.

3.3. Сав газрын захиргаа болон сум дүүргийн Засаг дарга нь хаягдал усыг энэхүү гэрээний 2.1-д заасан стандартын норматив шаардлагад нийцүүлэн цэвэрлэсэн, дахин ашигласан ус бохирдуулагчийг ус бохирдуулсны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх жагсаалтыг гаргана.

3.4. Сав газрын захиргаа болон дүүргийн Засаг дарга нь хаягдал ус хаях, зайлуулах шаардлагыг зөрчсөн ус бохирдуулагчийн хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг цуцална.

Дөрөв. Ус бохирдуулагчийн эрх, үүрэг

4.1. Ус бохирдуулагч нь Сав газрын захиргаанаас мэргэжил, арга зүйн зөвлөгөө авах, хаягдал ус хаях, зайлуулах цэг тогтоолгох, ногдуулсан ус бохирдуулсны төлбөр болон нөхөн төлбөрийн хэмжээг үндэслэлгүй гэж үзвэл дээд шатны байгууллагад гомдол гаргах эрхтэй.

4.2. Ус бохирдуулагч нь үйл ажиллагаандаа энэхүү гэрээг болон холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам, стандарт, норм, норматив, ТЭЗҮ, зураг төсөл, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг мөрдөж ажиллана.

4.3. Ус бохирдуулагч нь хаягдал усны ээлхүүнийг тодорхойлох хэмжих хэрэгсэл /тоолуур/-ийг “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам”-д заасны дагуу хаягдал усны шугамын гаргалгаан дээр суурилуулах тоолуур нь гаргалгааны шугамын голчтой адил байх бөгөөд мэдрэгчийн хийц нь хаягдал усны найрлагаас хамааран өөрчлөгдөх, эвдрэх, гэмтэх зэрэг эрсдэлээс хамгаалагдсан эд ангиар хийгдсэн байх шаардлагад нийцүүлэн суурилуулна.

Тав. Бусад

5.1. Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

5.2. Ус бохирдуулагч нь ус бохирдуулсны төлбөр, нөхөх төлбөрийг хугацаанд нь төлөөгүй бол Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

5.3. Энэхүү гэрээг сунгах, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой асуудлыг 2 тал харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ.

5.4. Энэхүү гэрээтэй холбогдон гарсан аливаа маргааныг эвийн журмаар шийдвэрлэхэд эрмэлзэх бөгөөд эс тохиролцвол иргэний журмаар шүүхээр шийдвэрлүүлнэ.

Зургаа. Давагдашгүй хүчин зүйлс

6.1. Ус бохирдуулагч нь давагдашгүй хүчин зүйл /тухайлбал: газар хөдлөлт, үер, гал түймэр, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл гэх мэт/-ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /нөхөн төлбөр, торгууль/ чөлөөлөгдөх үндэслэл болно.

6.2. Ус бохирдуулагч нь давагдашгүй хүчин зүйл бий болсныг нотолно.

**Гэрээ байгуулсан:**

Ус ашиглуулагчийг төлөөлж:

Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга
................................................/Ц.Тунгалаг/

Хаяг: УБ, Налайх дүүрэг, 2 дугаар хороо,

Утас: 70232419

Ус бохирдуулагчийг төлөөлж:

“МӨНХ АРИУН УНДАРГА” ХХК-ийн ажилтан

......Т.Болорцэцэг...... /..............................Болор/

Хаяг: Ху. Тул 20 хороо, Ургөөдүр 12

Утас: 91771111

## ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2023 оны 04 сарын 20 өдөр Дугаар 10 Налайх дүүрэг

**Гэрээний зорилго:** Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад “Хөдөлмөрийн тухай”, “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Аялал жуулчлалын тухай”, “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай”, “Хог хаягдлын тухай”, ”Зөрчлийн тухай” “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай”, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай” хууль холбогдох дүрэм, журам, дүүргийн удирдлагаас гарсан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангуулж, төр захиргааны эрх бүхий байгууллагаас дэмжлэг үзүүлэн, хяналт тавих, нөгөө талаас сайн дурын үндсэн дээр орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмрийн хүрээнд нийгмийн хариуцлагыг тодорхойлж, хамтран ажиллахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

### Нэг. Ерөнхий зүйл

Нэг талаас Дүүргийн удирдлагыг төлөөлж Налайх дүүргийн Засаг даргын орлогч Н.Мандуул (цаашид “Захиргааны байгууллага” гэх), нөгөө талаас Аж ахуйн нэгж, байгууллагыг төлөөж Налайх дүүргийн ..... хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 5235559 регистрийн дугаартай, “Мөнх-Ариун ундарга” ХХК-ийн захирал Д. Ариунзул (цаашид “ААН, байгууллага” гэх) нар нь хамтран дараах нөхцлүүдийг хэлэлцэн тохиролцож, харилцан зөвшөөрснөөр энэхүү гэрээг байгуулав.

1.1. Талууд бие биенийхээ үйл ажиллагааг харилцан хүндэтгэж, гэрээний заалтуудыг чанд мөрдөнө.

1.2. Гэрээг 2% үйлдэж, хоёр тал харилцан тохиролцон гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болох бөгөөд талуудад гэрээний 1 хувийг хадгалуулна.

1.3. Гэрээ нь 2023 оны 04-р сарын 20-ний өдрөөс 2024 оны 04-р сарын 20-ний өдөр хүртэл 1 жилийн хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

1.4. Аль нэг талын санаачлагаар гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд гэрээний нэгэн адил хүчин төгөлдөр үйлчилнэ.

### Хоёр. Нутгийн захиргааны байгууллагын эрх, үүрэг

2.1. Хууль тогтоомж, дүрэм, журам, төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагаас гаргасан тогтоол, шийдвэрийг аж ахуйн нэгж, байгууллагад сурталчлах ажлыг зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай үзүүлнэ.

2.2. Газар ашиглах, эзэмших үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчныг хамгаалах, түүний баялагийг зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар хууль тогтоомжинд заасан үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавьж, гарсан зөрчлийг таслан зогсоох арга хэмжээ авах.

2.3. Захиргааны байгууллага нь гэрээний хугацаанд аж ахуйн нэгж, байгууллагын нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн аливаа үйл ажиллагааг орон нутгийн иргэдэд тухай бүр нь үнэн зөв мэдээлж ажиллах

2.4. Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтарч сургалт, семинар, үзэсгэлэн худалдаа болон бусад арга хэмжээнд оролцуулах ажлыг зохион байгуулах

### Гурав. Аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг

3.1. Аж ахуйн нэгж, байгууллага нь өөрийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, дүрэм, журам, төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагаас гаргасан тогтоол, шийдвэрийг чанд биелүүлж, олон нийтийг хамарсан арга хэмжээ болон нийгмийн дэг журмыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхи санаачлагатай оролцох

3.2. Аж ахуйн нэгж, байгууллага нь орчны 50м хүртэлх газрын ашиглалт хамгаалалт, цэвэрлэгээ, халтиргаа, гулгааг хариуцан тогтмол цэвэрлэх, мод, бут, зүлэг тарьж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, орчны тохижилтод хувь нэмрээ оруулж, гаднах хаягаа гэрэлтдэг, товгор крилл үсгээр бичиж байршуулах, гэрэлтүүлгийг стандартын дагуу хийж гүйцэтгэх, хог хаягдлын гэрээ байгуулан ажиллах

3.3. Нийслэлийн агаарын бохирдлыг багасгах зорилтын хүрээнд өвлийн улирал сэргээгдэх эрчим хүчний бие даасан үүсгүүр, стандартын шаардлага хангасан хийн болон цахилгаан халаагуур, бүрэн шаталттай шахмал түлш ашиглах

3.4. Зориулалтын (2-3 хоногийн багтаамжтай) хогийн савтай байж, бохир усны цооног, бие засах газрыг стандартын шаардлага хангасан хөрс бохирдуулахгүй байдлаар шийдэх

3.5. Орон нутгийн нийгмийн халамж дэмжлэг шаардлагатай өрх, иргэдэд чиглэсэн тодорхой үйл ажиллагааг санаачлан хэрэгжүүлэх

3.6. Дүүрэгт ажлын байрыг нэмэгдүүлж, ажиллах хүчний 80 хүртэлх хувьд дүүргийн харьяалалтай иргэдийг хамруулж, ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулан, чадваржуулах ажлыг зохион байгуулж, ажиллагсдын хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл болон, тухайн дүүргийн иргэдийн аюулгүй байдлыг эн тэргүүнд тавьж, ажлын байран дахь аюул

эрсдлийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр ажилтантай мэдээлэл солилцож, хамтран ажиллах

3.8. Ажилчдыг нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалд хуулийн дагуу цаг хугацаанд нь хамруулах

3.9. Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана. /Хөдөлмөрийн сайдын 2016 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн №36 дугаар тушаалаар батлагдсан/

**Дөрөв. Гэрээ дуусгавар болох**

Дараах тохиолдолд гэрээ дуусгавар болно. Үүнд

4.1. Гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах талаар аль нэг тал нөгөө талдаа бичгээр мэдэгдсэн боловч нөгөө тал нь ажлын 14 хоногт багтаан асуудлыг шийдвэрлээгүй эсхүл хариу өгөөгүй тохиолдолд;

4.2. Гэрээний хугацаа дуусаж, цаашид сунгагдахгүй болсон.

4.3.Гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд гэрээг сунгахгүй.

4.4. Давагдашгүй хүчин зүйл /тухайлбал: үер, гал түймэр, газар хөдлөлт зэрэг байгалийн гамшиг, халдварт өвчний тархалт, дайн байлдаан, зэвсэгт мөргөлдөөн, террорист үйлдэл, иргэдийн үймээн, нийтийг хамарсан ажил хаялт, эрх бүхий байгууллагаас гаргасан хорио цээр гэх мэт/-ийн нөхцөл байдлын шууд болон шууд бус үйлчлэлийн улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй тохиолдолд гэрээг хүчингүйд тооцно.

**Тав. Нэмэлт нөхцөл**

.............................................................................................................................................................
.............................................................................................................................................................
.............................................................................................................

**Зургаа. Гэрээний хариуцлага, дүгнэх**

6.1. Талууд гэрээний биелэлтэд тавих хяналтыг хамтран хийж, оны эцэст үр дүнг тооцож гэрээг дүгнэнэ.

6.2. Дүүргийн ойн арга хэмжээ болон дүүргийн хөгжилд оруулах хөрөнгө оруулалтын ажлуудыг талууд харилцан зөвшилцөж, тухай бүрт нь шийдвэрлэн хамтран ажиллана.

6.3. Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага нь Монгол Улсын "Зөрчлийн тухай", "Хог хаягдлын тухай", "Байгаль орчныг хамгаалах тухай" болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

6.4. Холбогдох хууль тогтоомж, стандарт, гэрээгээр хүлээсэн үүргээ давтан зөрчсөн, иргэдийн эрх ашгийг ноцтой хохироосон нь тогтоогдсон нөхцөлд аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг холбогдох хуулийн байгууллагатай хамтран бүрэн зогсоох арга хэмжээ авна.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| ДҮҮРГИЙГ ТӨЛӨӨЛЖ: | АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫГ ТӨЛӨӨЛЖ: |
|---|---|
| ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ ..................... Н.МАНДУУЛ | "...Мөнх Ариун Ундарга..." ХХК-ИЙН ЗАХИРАЛ ...Д. Эрдэнэцэцэг... |
| 2023 оны 04 сарын 10 өдөр | 2023 оны 04 сарын 10 өдөр |
| | УТАС: |
| ХҮНС, ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА ..................... Ц.ТУНГАЛАГ | "...Мөнх Ариун Ундарга..." ХХК-ИЙН ...Шүхэр... АЖИЛТАЙ ...Эрдэнэцэцэг... |
| 2023 оны 04 сарын 10 өдөр | 2023 оны 04 сарын 10 өдөр |
| УТАС: 70232419 | УТАС: 91771111 |

## АЖ АХУЙ НЭГЖИЙН ХАРИУЦАХ ОРЧНЫ 50 МЕТРИЙН ЦЭГҮҮДИЙГ НЬ ГАЗАРТ БЭХЭЛСЭН НЭГЖ ТАЛБАРЫН ЗУРАГ

Нэгж талбарын дугаар:
Газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн овог, нэр: "Мөнх ариун ундарга" ХХК
Регистрийн дугаар: 5235359
Хаяг: Улаанбаатар хот, Налайх дүүрэг , 6-р хороо, Горхи-Тэрэлжийн БЦГазар Арагантын ам




Нэгж талбар:

| № | X | Y | Цэг | Зай |
|---|---|---|---|---|
| 1 | 5308725,208 | 682835,874 | 1-2 | 150,90 |
| 2 | 5308874,547 | 682857,502 | 2-3 | 88,66 |
| 3 | 5308922,337 | 682932,175 | 3-4 | 140,95 |
| 4 | 5308896,281 | 683070,696 | 4-5 | 210,55 |
| 5 | 5308692,976 | 683015,941 | 5-1 | 182,93 |

Зургийн масштаб 1:5000 (1 сантиметрт 50 метр багтана)

Эргэлтийн цэгүүдийг газар дээр нь тэмдэгжүүлж, солбицолжуулсан үндэслэлийн цэг:

Цэгийн солбицол 1: X . 5308642.259 . . . Y . 639764.975 . . . H . 1286.912 . . .
Цэгийн солбицол 2: X . . . . . . . . . . . . . . . Y . . . . . . . . . . . . . . . . . H . . . . . . . . . . . .
Цэгийн солбицол 3: X . . . . . . . . . . . . . . . Y . . . . . . . . . . . . . . . . . H . . . . . . . . . . . .

Талбайн хэмжээ: 39153 квадрат метр
Хэмжилт үйлдсэн:
Огноо 2021-10-21
Байгууллагын нэр "Сод сүрвей" ХХК
Хэмжигчийн нэр . . . . . . . . . . . . /Ц.Энхжаргал/

"Сод Сүрвей" ХХК
УЛААНБААТАР ХОТ

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

# БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

2023 оны 05 сарын 29 өдөр Дугаар 2023/28 Улаанбаатар хот

"МӨНХ АРИУН УНДАРГА" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Д.АРИУНЦЭЦЭГ ТАНАА

1. **Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр хаяг, утас факс, улсын бүртгэлийн дугаар:** "Мөнх ариун ундарга" ХХК-ний захирал Д.Ариунцэцэг, Хан-Уул дүүрэг, Шаравын гудамж-12, Утас: 11-343302, 70143302, 91771111, Факс-976-11-343302, Улсын бүртгэлийн дугаар: 9011156052, Регистрийн дугаар: 5235359.

2. **Төслийн байршил /ХӨ;ЗУ/:** Налайх дүүрэг, 6 дугаар хороо, Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолбор газар, Арагантын ам, 47°54'23.80"N,107°26'53.73"E

3. **Үйлдвэрлэл, үйлчилгээний нэр төрөл зориулалт:** 1.0 га газарт аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

4. **Үйлдвэрийн техник, технологи /ажиллах горим, хүчин чадал/:** "Мөнх ариун ундарга" ХХК-ны "Сац" эко аялал жуулчлалын бааз нь 1 ээлжиндээ 140 хүн хүлээн авах хүчин чадалтай. Нийтийн ОО, Бильярд өрөө 1, караоке өрөө 2, хүүхдийн тоглоомын өрөө 1, 40 хүн хүлээн авах хурлын заал, хүлээлгийн өрөө, сувинерийн өрөө, 2 давхарт оффис өрөө 1, зочин хүлээн авах өрөө 17, 3 давхарт 20 хүн хүлээн авах 10 өрөө, 54 хүн хүлээн авах 27 өрөөтэй. 22 ажилтан алба хаагчтай. Жилд 365 хоног ажиллана.

5. **Үйлдвэрлэх боловсруулах бүтээгдэхүүний хэмжээ:** Хүлээн авсан амрагчдыг тав тухтай амраах.

6. **Усны эх үүсвэр, нөөц, чанар, хоногт ашиглах хэмжээ: /шоо.метрээр/:** 62 м гүнтэй өрөмдмөл худагтай. Худгаас ундаргаар нь тооцож үзэхэд хоногт 129.6 $м^3$ ус ашиглах боломжтой. Жуулчны баазын усны хэрэглээг тооцож үзэхэд хоногт дунджаар 30.0 $м^3$ ус ашигласан тооцоо гарч байна.

7. **Усны барилга байгууламжууд /нэр, хүчин чадал, барилга, байгууламжийн хэмжээ хийц/:** Гүний худгаас өөр усны барилга байгууламж байхгүй.

8. **Худаг, өргөлтийн станцууд, усны тоолуур /Насосын хүчин чадал, марк/:** QJD 0.75 к вт 3тн ус өргөгч насосыг 55 гүнд байрлуулсан. 0010005061 дугаартай LXSG-25 загварын усны тоолуур суурилуулсан. 2023 оны 4-р сарын байдлаар тоолуурын заалт 03831 $м^3$.

9. **Хэрэглэгчээс гарах хаягдал бохир усны хэмжээ, цэвэрлэгээний арга, түвшин:** Жуулчны баазын барилгууд нь хоорондоо цэвэр, бохир усны шугамаар холбогдсон. Гэр буудлууд нийтийн ариун цэврийн өрөөтэй. Жуулчны бааз нь 140 хүн хүлээн авахад тохирсон ХБНГУ-ын BUSSE MBR компанийн бага оврын цэвэрлэх байгууламжийг барьж ашиглалтад оруулсан. Жуулчны баазаас гарсан ахуйн бохир усыг мембран биориакторын аргаар 99.97% хүртэл цэвэрлэх боломжтой.

10. **Байгаль орчны үнэлгээ, нөхцөл:** Эко аялал жуулчлалын баазын төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг 2020 онд "Мон газар экологи" ХХК-иар хийлгэж, Байгаль орчин, аялал жуулчлалын яамаар батлуулсан. Үнэлгээнд заасан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай.

11. **Онцгой нөхцөл:** Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Барилга хот байгуулалтын сайдын 2015 оны А-230/127 дугаартай тушаалаар батлагдсан "Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журмын 3.18 дахь заалтад заасны дагуу эрүүл ахуйн хориглолтын бүсийг байгуулан мөрдөж ажиллах.

12. **Холбогдох хууль, дүрэм, журам, норм стандартын дагуу усны зарцуулалтыг тооцох:**
   - 1 ажилчин албан хаагч өдөрт 180 л ус хэрэглэнэ гэж үзвэл: 22 ажилтан алба хаагч 365 хоног ажиллахад: 365 хон * 22 хүн * 180 л =1445.4 $м^3$;
   - 1амраагч өдөрт 180 л/хон ус хэрэглэнэ гэж үзвэл 140 амраагч 365 хоног ажиллахад: 365 хон *140 амрагч * 180 л/хон= 9198.0 $м^3$;
   - **Нийт 10643.4 $м^3$.**

13. **Холбогдох хууль, тогтоол шийдвэрийн дагуу оногдуулах усны нөөцийн төлбөрийн хэмжээ:** “Усны экологи, эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 302, "Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай", "Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" Монгол Улсын Засгийн газрын 326, 327 дугаар тогтоолуудыг үндэслэн төлбөрийг тооцоход:
   - 1$м^3$ усны нөөц ашигласны төлбөр 2*9440 төг/$м^3$*0.07*15%/100%= 198.24 төг

     9440 төг/$м^3$ – Экологи, эдийн засгийн суурь үнэлгээ;
     10% - Усны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээ;
     0.1 - Ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр;
     Улсын тусгай хамгаалалттай газар нутагт ус ашигласан тохиолдолд экологийн итгэлцүүрийг 2 дахин өсгөж тооцно.

   - 10643.4 $м^3$*198.24 төг= **2,109,947.61 төг** /Хоёр сая нэг зуун есөн мянга, есөн зуун дөчин долоон төгрөг, жаран нэгэн мөнгө/

   - **2023 онд тоолуурын заалтаас харахад 1190 $м^3$ ус ашиглаж 235,905.6 төгрөгний төлбөр гарсан байна.**

14. **Тавигдах шаардлага, цаашид авах арга хэмжээний талаарх зөвлөмж**:

- Усны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх заалтад заасны дагуу Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газартай 2023 оны ус ашиглах гэрээг тоолуурын 03831 $м^3$ заалтаас хойш тооцон байгуулах.

- 2023 оны усны нөөц ашигласны төлбөрийг Налайх дүүргийн Татварын хэлтсийн дансанд төлөх. 1 $м^3$ усны төлбөр 198.24 төг.

- Гүний худгийн уснаас улирал бүр дээж авч хими болон бактериологийн шинжилгээ хийлгэн ундны усны стандартын шаардлага хангасан тохиолдолд унд ахуйд усыг ашиглах.

- Тоолуурын заалтын баталгаа алдагдсан, шугам хоолойгоос салгасан тохиолдолд усны нөөц ашигласны төлбөрийг ус ашиглуулах дүгнэлтээр тооцож оногдуулахыг анхаарах.

- Жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан тухай оны ус ашиглуулах дүгнэлтийг гаргуулж байх. Дүгнэлтэд заасанаас илүү ашигласан усанд Засгийн газрын 2018 оны 391 дүгээр

тогтоолоор батлагдсан "Зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөр тооцох журам"-ын дагуу шатлан өсгөх хэлбэрээр тооцохыг анхаарах.

- Усны нөөц ашигласны төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд Усны тухай хуулийн 33.1.10-т заасны дагуу хариуцлага тооцохыг анхаарах.

- Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалтад заасны дагуу бохир ус хаях зайлуулах дүгнэлтийг Туул голын сав газрын захиргаанаас авч, дүүргийн Засаг даргын Тамгын газартай бохир ус хаях зайлуулах гэрээ байгуулах.

- Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг хэмнэлттэй байдлаар ашиглах шаардлагын хүрээнд гал тогоо, угаалгын өрөө, шүршүүрт мэдрэгчтэй төхөөрөмж суурилуулж усыг хэмнэх.

- Хур бороо цас мөсний усыг хуримтлуулж ногоон байгууламж, зам талбайн усалгаанд хэрэглэх.

- Байгууллагын хашаанд мод тарих, зүлэгжүүлэх ажлыг зохион байгуулах.

Хувийг: Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар, Татварын хэлтэст

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Р.ЭНХТАЙВАН

9022020311
9077049 & СБТ17769

ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГАА
“МӨНХ АРИУН УНДАРГА” ХХК-ИЙН
ХАЯГДАЛ УСНЫ ДҮГНЭЛТ

2023 оны 03 дугаар сарын 09 | Дугаар ХУД 23/15 | Улаанбаатар хот Утас:70003714, 70003716

**1.Иргэн, аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар:**

“Мөнх ариун ундарга” ХХК, Захирал Д.Ариунцэцэг, утас: 11-343302, 7014-3302, 9177-1111, Улсын бүртгэлийн дугаар 9011156052, Регистрийн дугаар 5235359.

**2. Төслийн нэр, байршил:**
- “Мөнх ариун ундарга” ХХК-ийн “САЦ” жуулчны бааз нь Улаанбаатар хот, Налайх дүүргийн 6-р хороо, Горхи-Тэрэлжийн БЦГ-т Арагант нэртэй газар байрладаг. Солбицол: 47°54'23.80", 107°26'53.73"

**3. Хаягдал ус хаях цэгийн байршил, координат:**
- Амралт бүрэн хүчин чадлаар ажилласан тохиолдолд хаягдал бохир усыг бетон доторлогоотой 2 цооногт хуримтлуулж “Чандмань-Налайх” ОНӨААТҮГ-тай 2022 оны 03 дугаар сарын 14-ний өдөр байгуулсан гэрээний дагуу соруулж Налайх дүүргийн 5 дугаар хороонд байрлах бохирын худагт нийлүүлдэг.

**4. Цэвэрлэгээний арга, түвшин:**
- ХБНГУ-ын BUSSE MBR компанийн хаягдал ус цэвэрлэх бага оврын цэвэрлэх байгууламжтай. Цэвэрлэх байгууламж нь хэрэглээнээс гарсан хаягдал, бохир усыг мембран биориакторын аргаар 99.97% цэвэршүүлдэг.

**5. Хаягдал усны хэмжээ, бохирдуулах бодис:**
- 2022 оны хаягдал усны нийт хэмжээ: 984.0 м$^3$ /Цэвэр усны тоолуурын заалт/.

- 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн тоолуурын заалт: 02801 м$^3$.

- 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн тоолуурын заалт: 03785 м$^3$.

**6. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ, төрөл:**
- Бохирдуулах бодисын хэмжээг Байгаль орчин, аялал жуулчлалын Сайд, Барилга хот байгуулалтын Сайдын 2019 оны А-816/218 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын жишиг хэмжээг тогтоох тухай” жишиг хэмжээгээр тооцов. Бохирдуулах бодисын төрөл, Органик бодис /Химийн хэрэгцээт хүчилтөрөгч/, Бохирдуулах бодисын жишиг хэмжээ: 1.50 кг/м$^3$

**7. Ус бохирдуулсны төлбөр тооцоо:**

| Хаягдал усны хэмжээ (м$^3$) | Жишиг хэмжээ (кг/м$^3$) | Бохирдуулах бодис (кг) | Ус бохирдуулсны төлбөр (төг/кг) | Нийт төлбөр, төг |
|---|---|---|---|---|
| 984.0 м$^3$ | 1.50 | 1'476 | 50.0 | 73'800.0 |

- Ус бохирдуулсны төлбөр: 73'800.0 /Далан гурван мянга найман зуун/ төгрөгийг Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4.10, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д заасны дагуу 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн дотор харьялах Татварын хэлтсийн дансанд төвлөрүүлнэ.

**8. Хууль тогтоомж, дүрэм, журам, норм стандартын талаар зөвлөмж:**
- Хаягдал усны бохирдуулах бодисын агууламж нь “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015” стандартаас давсан тохиолдолд Усны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2, Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2019 оны А/635 дугаар тушаалаар батлагдсан “Ус бохирдуулсны нөхөн төлбөрийг шатлан өсгөх хэлбэрээр ногдуулах журам”-ын дагуу нөхөн төлбөр ногдуулахыг анхаарах;

ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГАА

- Байгаль орчин, ногоон хөгжлийн Сайдын 2013 оны А-156 дугаар тушаалаар батлагдсан *“Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам”*-ын 2.1.4, 3.6.1 дэх заалтын дагуу хаягдал усны эх үүсвэрийг тоолууржуулах.

***9. Тавигдах шаардлага, цаашид авах арга хэмжээ:***

- Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-д заасны дагуу Налайх дүүргийн засаг даргаас хаягдал ус хаях зөвшөөрөл авч гэрээ байгуулах шаардлагатай;
- Хаягдал усны дүгнэлтийг жил бүрийн эхний улиралд багтаан гаргуулах бөгөөд улирал бүр хоёроос доошгүй хаягдал усны сорьц авч итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэн, сүүлийн сарын 15-ны дотор ирүүлж байх;
- Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5, 17 дугаар зүйлийн 17.1.5-д заасны дагуу сав газрын усны мэдээллийн дэд сан бүрдүүлэхэд шаардлагатай хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийн бичиг, хаягдал усны шинжилгээний дүнгүүд, хаягдал усны төлбөр төлсөн баримтыг 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор Туул голын сав газрын захиргаанд ирүүлэх.

ХЯНАСАН:
УСНЫ НӨӨЦ, УС АШИГЛАЛТЫГ ЗОХИЦУУЛАХ
АЛБАНЫ ДАРГА П.ЭНХБАЯР

ДҮГНЭЛТ ГАРГАСАН:
УСНЫ НӨӨЦ, УС АШИГЛАЛТЫГ ЗОХИЦУУЛАХ
АЛБАНЫ МЭРГЭЖИЛТЭН Э.МЯГМАРСҮРЭН

УЛААНБААТАР ХОТ

Батлав. “Цасны хачир” ХХК-ний
Захирал Д.Алтанцэцэг

5235359 ХАК5809
МӨНХ АРИУН УНДАРГА ХХК
УЛААНБААТАР ХОТ

Батлав Мөнх Ариун Ундарга ХХК-ний
Захирал: ...

## Ахуйн шавьж, мэрэгч устгал, халдваргүйтгэлийн хамтран ажиллах гэрээ

2019 оны 10 сарын 16 өдөр № 0518 Улаанбаатар хот

### Нэг. Ерөнхий зүйл

1. Хамтран ажиллах гэрээг нэг талаас “Цасны хачир” ХХК- АШМУХ алба /цаашид үйлчлэгч гэх/ төлөөлж захирал Д.Алтанцэцэг, нөгөө талаас Улаанбаатар хотын ХУД дүүргийн 2-р хороонд байрлах Мөнх Ариун ...-г /цаашид үйлчлүүлэгч гэх/ төлөөлж Ундарга ХХК албан тушаалтай Гүйцэтгэх захирал ... нь “Эрүүл мэндийн тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжуудыг удирдлага болгон үүрэг хүлээж дор дурьдсан зүйлүүдийг харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээг байгуулав.

### Хоёр. Нийтлэг үндэслэл ба зорилго

2.1 Монгол улсын MNS 5161-3:2002 стандартын үйлчилгээний технологийг баримтлан аливаа халдварт өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, өвчин тээгч нянг болон тэдгээрийг дамжин тараагч хүчин зүйл болсон ахуйн шавьж, мэрэгчийн биологийн хөгжлийн өсөлт бойжилтын давтамжийг таслан зогсоох, мөн байгаль цаг уурын нөхцөл байдалтай уялдуулан устгах, халдваргүйжүүлэх үйлчилгээг төлөвлөгөө графикийн дагуу тогтмол хийж , хүн амын эрүүл аюулгүй орчинд ажиллаж, амьдрах эрхийг баталгаажуулахад гэрээний гол зорилго оршино.

### Гурав. Үйлчлүүлэгч байгууллагын үүрэг

3.1. Үйлчилгээг үр дүнтэй болгох үүднээс бүх талбайг бүрэн хамруулна.
   а. Шавьжгүйтгэлийг ............ $m^2$-д жилд 2 удаа ............... төгрөг
   б. Халдваргүйтгэлийг ...........$m^2$-д жилд 4 удаа ................төгрөг
   в.Мэрэгчгүйтгэлийг .......... $m^2$-д жилд 2 удаа................төгрөгөөр хийж гүйцэтгэнэ.

3.2. Гэрээний дагуу тохиролцсон хугацаанд үйлчилгээг хийлгэхээс гадна урьдчилсан бэлтгэл ажил, чийгтэй цэвэрлэгээг чанарын өндөр түвшинд хийж, обьектоо бүрэн хамруулах арга хэмжээг авна.

3.3 Үйлчилгээ хийлгэснээс хойш үйлчлэгч байгууллагын устгал халдваргүйтгэлтэй холбоотой өгсөн мэргэжлийн заавар зөвлөгөөг мөрдлөг болгон ажиллах

3.4 Ямарваа нэгэн шавьж, мэрэгч илэрсэн тохиолдолд үйлчлэгч байгууллагадаа даруй мэдэгдэж тандалт судалгаа хийлгэх үүрэг хүлээнэ.

3.5 Үйлчилгээ гүйцэтгэсний дараа үйлчилгээний төлбөрийг батлагдсан тарифын дагуу төлөх ба нэхэмжлэлээр төлөх бол ажлын 3 хоногт багтаан Улаанбаатар банк: 2611138817 тоот дансанд шилжүүлнэ.

3.6. Үйлчилгээ хийлгэснээс хойш үйлчлүүлэгч байгууллагад шавьж устгал, мэрэгчийн өгөөш болон бусад бодисны заавар зөвлөмжийг өгсөн ч мөрдөөгүйгээс үүдэн гарсан эрсдлийг үйлчлүүлэгч байгууллага өөрөө хариуцна.

3.7 Үйлчлэгч байгууллагын эрүүл ахуйч эмч, ариутгагч нар нь ажил эхлэхээс өмнө ХАБЭА-н зааварчилгааг тогтмол авч гарын үсэг зурдаг бөгөөд үйлчлүүлэгч байгууллага үйлчилгээ хийхээр очсон ажилчдын аюулгүй ажиллагааны шаардлага хангасан нөхцөлийг бүрдүүлэн ажиллах үүрэгтэй.

## Дөрөв. Үйлчлэгч байгууллагын үүрэг

4.1. Гэрээнд заасан хугацаанд шавьж, мэрэгч, халдваргүйтгэлийн үйлчилгээг MNS 5161-3:2002 стандартын технологийн дагуу чанартай хийхээс гадна, заавар зөвлөмжийг танилцуулж санамж үлдээн гарын үсэг зуруулна.
4.2. Үйлчилгээ гүйцэтгэсний дараа үйлчлүүлэгчийн хүсэлтийг харгалзан цаашид авах арга хэмжээг хэрэгжүүлнэ.
4.3. Улирал тутам давтан хийх гүйцэтгэлийг 1-3 хоногийн өмнө утсаар мэдэгдэж цэвэрлэгээ, үйлчилгээ хийлгэхийг анхааруулна.
4.4. Үйлчилгээний төлбөрийг тарифын дагуу үйлчлүүлэгч байгууллага хариуцна.
4.5. Шавьж, мэрэгч, халдваргүйтгэлийн үйлчилгээг үзүүлсний дараа ажлын гүйцэтгэлийн акт болон анхан шатны бүртгэлийг тогтмол хөтөлнө.
4.6. MNS 5161-3:2002 стандартын 9.8, 9.9, 9.12 дах заалтуудыг мөрдлөг болгон ажиллана.
4.7. Шавьж, мэрэгч, халдваргүйтгэлийн үйлчилгээг чанарын өндөр түвшинд хийх ба БОАЖЯ, ХХААХҮЯ, ЭМЯ-н сайд нарын хамтарсан тушаалаар баталсан хор бодис болон түүний аюулгүй ажиллагааны заавартай МХТ лабораторын шинжилгээний дүгнэлттэй сүүлийн үеийн бодисоор үйлчилнэ.
4.8 Гэрээний 3.1, 3.2, 3.3 заалтуудтай холбоотой үйлчлүүлэгчийн хариуцлагаас үүссэн хохирлыг үйлчлэгч байгууллага хүлээхгүй болно.

## Тав. Хамтран хүлээх үүрэг

5.1. Тухайн байгууллагад үйлчилгээ хийж буй нөхцөлд үйлчлүүлэгч талаас төлөөлөгч томилон, үйлчлэгч талын эрүүл ахуйч,ариутгагч нартай хамтран дотоод хяналт хийж үр дүнг тооцон ажиллана.
5.2. Гэрээ байгуулсан 2 тал дур мэдэн гэрээг цуцлахыг хориглоно.
5.3. Үйлчлүүлэгч байгууллага нь гэрээг дур мэдэн цуцласан тохиолдолд үйлчлэгч байгууллагын гэрээний хугацаанд хийх ажлын гүйцэтгэлийн үнийн дүнг төлж барагдуулах үүрэгтэй.
5.4. Энэхүү гэрээрээр хүлээсэн үүрэг болон 5.2, 5.3-т заасныг аль нэг тал биелүүлээгүй тохиолдолд хоёр талаас төлөөлөл томилон асуудлыг шийдвэрлэнэ.
5.5. Асуудал шийдэгдэхгүй тохиолдолд Монгол улсын хуулийн заалтаар шийдвэрлэнэ.

## Зургаа. Гэрээний хугацаа

6.1. Тогтвортой үйл ажиллагаа явуулахын тулд хоёр байгууллага харилцан тохиролцож 1-3 жилийн гэрээг байгуулна.
6.2. Гэрээг 2% үйлдэж гарын үсэг зуран тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.
6.3. Ямар нэгэн маргаан гараагүй тохиолдолд гэрээг цаашид хүчинтэйд тооцно.

## Долоо. Гэрээний сунгалт

7.1. 2019 оны 10 сарын 16-ны өдрөөс 2022 оны 10 сарын 16 өдөр хүртэл хүчинтэй.
2022 оны 10 сарын 16-ны өдрөөс 2024 оны 10 сарын 16 өдөр хүртэл хүчинтэй.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН**

| Үйлчлэгч байгууллагыг төлөөлж: | Үйлчлүүлэгч байгууллагыг төлөөлж: |
|---|---|
| ..................ажилтан | ..................ажилтан |
| [signature] ................ | [signature] ................ |
| Утас: 9960-8691<br>8602-1119<br>8881-9486<br>91017066. | Утас: 91771111 |

БАТЛАВ:
**“МӨНХ АРИУН УНДАРГА” ХХК-ИЙН**
ЗАХИРАЛ:
……………………………/Д.АРИУНЦЭЦЭГ/

БАТЛАВ:
**“МАРГАД ЭРДЭНЭ УУЛ” ХХК-ИЙН**
ЗАХИРАЛ:
……………………………/Е.МАНДАХ/

**ХЭРЭГЛЭЭНЭЭС ГАРСАН ШИНГЭН ХОГ ХАЯГДАЛ ЗӨӨВӨРЛӨХ, ШУГАМЫН БӨГЛӨРӨЛ ГАРГАХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

**Дугаар: AR / 22 / 43**

2022 он 11 сар 01 өдөр Улаанбаатар хот

Нэг талаас **“МӨНХ АРИУН УНДАРГА” ХХК** (цаашид “Захиалагч” гэх) /РД: 5235359/, түүнийг төлөөлж …Менежер…. албан тушаалтай …Тэлмэн…. нөгөө талаас **“МАРГАД ЭРДЭНЭ УУЛ” ХХК** (цаашид “Гүйцэтгэгч” гэх) /РД: 6342612/, түүнийг төлөөлж менежер Ж.Марал нар доорх нөхцлөөр харилцан тохиролцож байгуулав.

**Нэг. НИЙТЛЭГ ЗААЛТ**

1.1. Гүйцэтгэгч тал захиалагчийн хүсэлтээр бохир ус тээвэрлэх үйлчилгээг чанартай, түргэн шуурхай хийж гүйцэтгэнэ.
1.2. Дээрх ажил нь байгаль хамгаалах хууль, ариун цэврийн тухай хууль, бусад холбогдох дүрэм зааварт бүрэн нийцсэн байна.
1.3. Хоёр тал харилцан тохиролцсоноор үйлчилгээний ажлын гүйцэтгэл доорх үнэтэй байна. Бохир ус цэвэршүүлсэний төлбөр багтсан болно. Үүнд:

**10тн – 255,000₮** / Хоёр зуун тавин таван мянган төгрөг/
**Буудлага – 300,000₮** / Гурван зуун мянган төгрөг /
/Буудлага - Худаг хоорондын бөглөрлийг усаар буудаж гаргах, бохирын лагийг өндөр даралттай усаар хөдөлгөж соруулах/

1.4. Ажил гүйцэтгэх хугацааг хоёр тал харилцан тохиролцож тогтоох бөгөөд энэхүү гэрээ нь 2022 оны 11 сарын 01-ний өдрөөс 2024 оны 11 сарын 01-ний өдөр хүртэл хүчинтэй байна.
1.5. Гэрээний хүчинтэй хугацаа дуусгавар болсон ч аль нэг тал цуцлах тухай бичгээр мэдэгдээгүй тохиолдолд гэрээг 1 жилээр сунгасанд тооцно.

**Хоёр. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

2.1. Үйлчилгээний дуудлагыг тухайн бохир ус тээвэрлэлт хийлгэх өдрийн өмнөх өдөр гүйцэтгэгчид өгсөн байна. /Дуудлагын утас: 9626-7373/
2.2. Бохир ус сорох явцад хяналт тавьж, дутуу сорсон тохиолдолд тухай бүрт нь гүйцэтгэгчид мэдэгдэж, шаардлага тавьж, доголдлыг тогтоон өөрийнх нь зардлаар дахин соруулна.
2.3. Гүйцэтгэгч талтай тохирсоны дагуу аливаа урамшуулал, хөнгөлөлтийг нэмэлт нөхцөлд заасны дагуу эдэлнэ.
2.4. Зайлшгүй шаардлагатай нэмэлт ажил /шугамын бөглөрөл гаргах, лайдах, худаг цэвэрлэгээ гэх мэт/ гарвал үйлчилгээг гүйцэтгэгчтэй харилцан тохиролцсоны дагуу үйлчилгээ хийлгэнэ.
2.5. Төлбөрийг бэлэн болон дансаар тохиролцсоны дагуу төлнө.

2.6. Ажлын хөлсийг дараа сарын хуанлийн эхний 5 /тав/ өдөрт нэхэмжлэх бөгөөд нэхэмжилсэнээс хойш захиалагч тал хуанлийн 5 /тав/ өдөрт багтаан гүйцэтгэгчид төлнө. Нэхэмжилсэн дүнг “МАРГАД ЭРДЭНЭ УУЛ” ХХК-ийн 5009952783 /Хаан Банк/ тоот дансанд шилжүүлнэ.

## Гурав. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Гүйцэтгэгч нь захиалагчийн өгсөн дуудлагын дагуу бохир ус тээврийн ажил гүйцэтгэлийг 8-10 цагийн дотор шуурхай хийж гүйцэтгэнэ.

3.2. Захиалагчийн соруулуулах бохирын цооногийг судалж үнийн дүнг тогтоох, өөрчлөх талаар санал тавьж тохиролцоно.

3.3. Гүйцэтгэгч тал ажил гүйцэтгэхээр очсон үед дуудлага өгсөн захиалагч талаас биеэр хяналт тавина.

3.4. Хяналт тавиагүйгээс гарах асуудлыг гүйцэтгэгч тал хариуцахгүй.

3.5. Үйлчилгээ гүйцэтгэх явцад захиалагч талаас шалтгаалж /бохирын хоолойн бүрэн бус байдал, ус алдалт, цооног, хөлдөлт гэх мэт/ доголдол гарвал гүйцэтгэгч тал дахин үйлчилгээ хийж, ажлын хөлсийг нэмж тооцон нэхэмжилнэ.

3.6. Гүйцэтгэгч тал нь захиалагч талын орчин тойрон болон эрүүл ахуй, аюулгүй байдлыг ханган ажиллана.

3.7. Гэрээний хугацаа дуусах хугацаанаас өмнө урьдчилан мэдэгдэлгүй гэрээг цуцалж өөр байгууллага, хувь хүмүүсээр үйлчилгээ хийлгэсэн тохиолдолд гэрээ дуусах хугацаа хүртэл гүйцэтгэгч ажил үүргээ гүйцэтгэсэнд тооцон тухайн хугацаанд гүйцэтгэх байсан ажлын өртгийг үл маргах журмаар нөхөн авах эрхтэй.

## Дөрөв. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

4.1. Захиалагч болон гүйцэтгэгч талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд үнийн дүнгийн 0,5% -тай тэнцэхүйц торгууль хүлээнэ.

4.2. Захиалагч гэрээнд заасан үүргээ өөрийн буруугаас биелүүлээгүй, зохих ёсоор гүйцэтгээгүй бол гүйцэтгэгчид учирсан зардал, хохирлыг хариуцана.

4.3. Талууд гэрээний хугацаа дуусахад хийж гүйцэтгэсэн ажлыг харилцан ярилцаж, “Гэрээ дүгнэх хуудас” -г бөглөж, гэрээг шинэчилэн байгуулна.

4.4. Хэрэв талуудын хооронд маргаан гарсан тохиолдолд талууд үл маргах журмаар шийдвэрлэх ба маргаанаа шийдвэрлэж чадахгүйд хүрвэл шүүхэд нэхэмжлэл гаргаж шийдвэрлүүлнэ.

4.5. Гүйцэтгэгч талын буруутай үйлдлээс болж захиалагч талын эд хөрөнгө эвдэрч гэмтсэн тохиолдолд гүйцэтгэгч тал бүрэн хариуцаж зах зээлийн үнээр төлж барагдуулна.
/Үүнд: хашаа хайс, бордюр, зүлэг ногоо гэх мэт/

4.6. Бохирын цооног хогтой байснаас гүйцэтгэгч талын машин техникт гэмтэл гарвал гүйцэтгэгч талын хохирлыг захиалагч тал бүрэн хариуцаж барагдуулна.

4.7. Гүйцэтгэгч тал бохир тээвэрлэхээр очих үед машины ёмкость ямагт хоосон байна.

## Тав. ГЭНЭТИЙН БОЛОН ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

5.1. Давагдашгүй хүчин зүйл /тухайлбал: үер, гал түймэр, газар хөдлөлт, халдварт өвчний тархалт, цаг агаарын саатал, зам боогдох, зэвсэгт мөргөлдөөн, террорист үйлдэл, иргэдийн үймээн, ажил хаялт гэх мэт/, нөхцөл байдлыг арилгах хүртэл ажил гүйцэтгэх хугацааг хойшлуулж болно.

5.2. Гэрээний үүргийг биелүүлэхэд саад болох нөхцөл байдал үүссэн, дууссан тухай талууд нэн даруй нэг нэгэндээ бичгээр мэдэгдэнэ.

## Зургаа. НЭМЭЛТ НӨХЦӨЛ

6.1. Захиалагч бохирын цооногийн бүрэн бүтэн байдлыг хангаж хогтүй цэвэр байлган машины орц, гарцыг чөлөөтэй байлгана.

6.2. Бохирын цооногтой холбоотой нэмэлт үйлчилгээ /худаг цэвэрлэгээ, лайдах, бөглөрөл гаргах, буудлага хийх гэх мэт/ хийх шаардлагатай үед талууд төлбөрийг харилцан тохиролцож, гүйцэтгэгч тал чанартай түргэн шуурхай хийж гүйцэтгэнэ.

6.3. Бензин шатахууны үнэ нэмэгдэхэд тээврийн хөлсийг дахин ярилцан тохиролцож тодорхой хувиар нэмнэ.

## Долоо. ГЭРЭЭНД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

7.1. Ажил гүйцэтгэх явцад гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Нэмэлт өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг байна.

## ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТАЛУУД:

**"МӨНХ АРИУН УНДАРГА" ХХК**

Хаяг: Налайх дүүрэг,
…6 хороо, Адармит…………
Утас: 91771111
И-Мэйл: hotelsats@gmail.com

…Менежер………:
……[signature]…… / Баатаржаргал
Утас: ………………
И-Мэйл: ………………………………

Нягтлан бодогч:
……[signature]…… / Буянжаргал
Утас: 99669797
И-Мэйл: ………………………………

**"МАРГАД ЭРДЭНЭ УУЛ" ХХК**

Хаяг: Улаанбаатар хот, БГДүүрэг,
3-р хороо, Энгельсийн гудамж, 3-176
Утас: 9626-7373, 8801-4140
И-Мэйл: margaderdeneuul@gmail.com

Менежер:
………[signature]……… / Ж.Марал /
Утас: 9626-7373
И-Мэйл: margaderdeneuul@gmail.com

Нягтлан бодогч:
………[signature]……… / Б.Эрхэмжаргал /
Утас: 9912-1354
И-Мэйл: margaderdeneuul.office@gmail.com